



**The Asia Foundation**

**Монгол улс дахь Хариуцлагатай уул уурхайн төлөөх олон  
талын оролцоот үйл явцын үнэлгээ**

**2006 оны 6 сар - 2007 оны 7 сар**



**Алдер Коварик, Флетчерийн сургууль,  
Тафтс Их Сургууль**

**2007 оны 8 сар  
Улаанбаатар  
Монгол улс**

## Гарчиг

I.	Гүйцэтгэлийн хураангуй .....	3
II.	Танилцуулга .....	5
1.	Өмнөх үг: Энэхүү үнэлгээг хэрхэн ашиглах вэ?.....	5
2.	Түүхэн үндэслэл.....	5
3.	Үнэлгээний зорилго .....	7
4.	Үнэлгээний арга зүй .....	7
III.	Олон талын оролцоот үйл явцын талаарх санал бодол.....	8
1.	Үйл явцын хэрэгжилт болон сул талууд.....	8
2.	Бүтээгдэхүүний давуу талууд болон тулгараад буй сорилтууд .....	10
IV.	Цаашдын чиглэл – Дараа нь яах вэ?.....	11
1.	Олон талын оролцоот үйл явц нь Монгол улсын хариуцлагатай уул уурхайн хөгжилд хэрхэн тус нэмэр болох асуудалд анхаарах хамгийн чухал цаг үе.....	12
	Логик хүрээллийн хэлбэр.....	15
2.	Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх стратегийн жишээ.....	16
3.	Олон нийтийн оролцоо, боловсрол мэдлэг, мэдээлэл түгээлтийн олон түвшин шаардлагатай байна .....	18
4.	Хариуцлагатай уул уурхайн төв болох санаа.....	21
5.	Найман зарчимд тохируулан стандартуудыг боловсруулах.....	22
V.	Асуудлын гол цэг.....	24
1.	Эрх зүйн асуудлууд .....	25
2.	Гар аргаар ашигт малтмал ашиглах асуудлууд.....	25
3.	Ил тод байдал .....	25
4.	Газрын хэвлийн нөхөн сэргээлт .....	26
5.	Бусад асуудлууд .....	26
VI.	Дүгнэлт.....	26
1.	Үйл ажиллагаа явуулах хувилбаруудын талаарх тойм .....	26
2.	Харгалзан үзэх асуудлууд .....	27

## I. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Энэхүү үнэлгээ нь тухайн үйл явцад оролцогчдын зүгээс Монгол улс дахь хариуцлагатай уул уурхайн асуудлаарх олон талт уулзалтын давуу талууд, сорилтууд болон хэтийн төлөвийн талаарх асуудлуудыг дэвшүүлэн гаргасан болно. Үнэлгээний зорилго нь олон талын оролцогчдын уулзалтын үйл явцын дэвшил, хөгжлийг хянаж мониторинг хийн, үүний оролцогчдод цаашдын чиглэл болон үйл ажиллагаагаа тодорхойлоход нь туслалцаа үзүүлэх явдал юм. Үнэлгээний үйл ажиллагааг АНУ-ын Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газраас санаачлан, хэрэгжүүлж буй олон талт уулзалтын үйл ажиллагааг зохион явуулах ажил, үүргийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үнэлгээний өөр нэгэн зорилго нь олон талын оролцогчдын уулзалтын үйл явцын ил тод, нээлттэй байдлыг ханган энэхүү үйл явц болон үүнээс гарах үр дүнг сайжруулах эх үүсвэр болох явдал юм.

Олон талын оролцогчдын уулзалтын үйл явцыг Монголчууд талархан хүлээн авсан бөгөөд үүнийг уул уурхайн салбар, үүний хөгжлийн талаарх хэлэлцүүлэг, хамтын ажиллагааг бий болгох болон мэдээллийг нээлттэй болгох, түгээх шаардлагуудын нэгэн гол үр дүн хэмээн хүлээн авсан. Оролцогчдын уулзалт нь нийгэм, байгаль орчны хувьд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн бий болгох зорилгын үүднээс төрийн байгууллагууд, бизнес эрхлэгчид болон иргэний нийгмийн төлөөлөл хамрагдан оролцсон юм. 2006 оны 11 дүгээр анх үүсэн бий болсноос хойш, тус бүр нь 60 гаруй оролцогчдыг хамарсан 5 удаагийн уулзалт зохиогджээ. Эдгээр уулзалтууд нь сонирхож буй бүх талуудад нээлттэй байсан байна. Үүнээс гадна үйл явцын томоохон төлөөлөл болох 14 гишүүн бүхий ажлын хэсэг байгуулагдан байнгын үйл ажиллагаа явуулж, холбогдох уулзалтуудыг зохиож байжээ. Одоогийн байдлаар олон талт уулзалтын үйл явц нь хариуцлагатай уул уурхайн тодорхойлолтын талаар харилцан ойлголцолд хүрч, хариуцлагатай уул уурхайн үндэс болох найман зарчмыг гаргаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, дэмжих талаарх тунхагт гарын үсэг зурах үйл ажиллагааг эхлүүлээд байна. Энэхүү тунхаг нь гарын үсэг зурж буй талуудын хоорондын харилцан ойлгоцлын санамж бичгийн үүргийг гүйцэтгэж байна.

Судлаач нь энэхүү үнэлгээний мэдээллийг оролцогчдын санал, бодолд үндэслэн нээлттэй ярилцлагийн аргаар цуглуулсан болно. Нийт дүнгээр судлаач нь 22 төлөөлөлтэй ярилцлага хийсэн нь үйл явцын байнгын оролцогчдын 28% байлаа.

### *Гол ололтууд - Олон талын оролцогчдын уулзалтын санал бодол*

- ❖ **Оролцогчид тухайн үйл явцыг ерөнхийдөө амжилттай байсан** хэмээн дүгнэсэн бөгөөд ярилцагчдын 82% нь аргачлал, үйл явц болон уулзалтуудаас гарсан үр дүнгүүд, ахиц дэвшилд сэтгэл хангалуун байна.
- ❖ Ярилцагчдын 55% ийн үзэж байгаагаар тухайн үйл явцын **хэлэлцүүлэг болон хамтын ажиллагааг** өндрөөр үнэлэх хэмжээнд байсан байна. Ярилцагчдын үзэж байгаагаар бусад оролцогчидтой яриа хэлэлцүүлэг өрнүүлж, хамтран сүлжээнд нэгдэн ажиллах боломж олгосон нь үйл явцын чухал хэсэг байжээ.
- ❖ Оролцогчдын гаргасан саналаас үзвэл тухайн **үйл явцад дэмжлэг үзүүлсэн болон зохион байгуулалтыг** хийсэн Азийн сангийн үүрэг ролийг үнэлсэн байна. Оролцогчид өөрсдөө хэлбэр, удирдлага, уулзалтын бүтэц зэргийг батлан гаргасан бөгөөд харин зарим оролцогчын үзэж байгаагаар ажлын хэсгээс нэгдсэн бүлэгт тайлагнах байдлыг улам сайжруулж болох байжээ.

- ❖ Ярилцагчдын гучин хоёр хувь нь **уул уурхайн компаниудаас илүү их төлөөлөл** оролцуулсан бол энэхүү үйл ажиллагааг улам сайжруулж салбар дахь олон ургалч үзэл бодлыг гаргахад тустай байх байсан хэмээн үзжээ.
- ❖ Оролцогчид ерөнхийдөө үйл явцад сэтгэл хангалуун байгаа бөгөөд **тодорхойлолтууд болон тунхаг нь үйл явцын чухал хэсгийг бий болгосон** хэмээн үзэж байна. Энэхүү үйл явцын гол ололт нь тодорхойлолт, зарчмууд, болон тунхаг хэмээн үзэж байгаа бөгөөд эдгээр нь оролцогчдод нэгдсэн ойлголтод хүрч харилцан ойлголцоход тус болсон хэмээн үнэлж байна.
- ❖ Гэхдээ ярилцагчдын 45% нь энэхүү баримт бичгүүдээр хязгаарлагдах бус харин хариуцлагатай уул уурхайг бий болгоход **үйл ажиллагаа явуулж асуудлуудыг шийдэж эхлэх** нь зөв гэж үзжээ.

### **Гол үр дүн- Олон талын оролцогчдын уулзалтын явцын ирээдүй**

Оролцогчдын гаргасан санал бодолд зарим нэгэн анхаарууштай зүйлсийг дурдсан ба үүнд ямар үйл ажиллагааг олон талт уулзалтын үйл явц ойрын үед гүйцэтгэх болон тухайн үйл явцыг урт хугацаанд хэрхэн төсөөлж байгаагаа өгүүлсэн байна.

- Хэдийгээр оролцогчид хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, шинэ түвшинд гаргах нэгдсэн нэг зорилготой байгаа ч энэхүү зорилгодоо хүрэхийн тулд тухайн олон талт уулзалт нь цаашдаа урт хугацаанд ямар ажлыг хийх талаар тодорхой ойлголт бага байна. Оролцогчдын өгсөн санал, хүсэлтээс харвал **одоо хариуцлагатай уул уурхайд хэрхэн тус нэмрээ үзүүлж чадах вэ гэдэг дээр төвлөрөх хамгийн чухал цаг үе** болоод байгаа ажээ. Нийт зорилгод хувь хүний үйл ажиллагаанууд нь хэрхэн тус нэмэр болж чадахыг ойлгохын тулд, олон талт уулзалт нь өөрийн хэтийн төлөв, зорилтыг тогтоох болон үйл ажиллагааны тэргүүлэх салбарыг тогтоох зэрэг ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
- Оролцогчдын хүсэлтээр, **хариуцлагатай уул уурхайг шинэ шатанд гаргах механизмын жишээг** өөр бусад оролцогчид болон санаачлагуудаас авч хэрэглэн үүний санаа болон сонголтуудыг олон талт уулзалтын бүлэгт хэрэгжүүлэх нь чухал байна.
- Олон талт уулзалтын бүлгээс эрхлэн явуулах ойрын хугацааны үйл ажиллагааны талаар хамгийн олон удаа дурьдагдсан үйл ажиллагаа нь **бүх түвшинд олон нийтийн оролцоог хангах, мэдлэг олгох болон мэдээлэл түгээх үйл ажиллагаанууд** байлаа. Ярилцагчдын 68 хувь нь олон талт уулзалтын бүлгийн үйл ажиллагаа зөвхөн нийслэл хотод ихээр төвлөрөх биш, харин бусад бүс нутгуудад хүрч олон нийтийн оролцоог хангах, боловсрол олгох болон мэдээлэл түгээх үйл ажиллагааг явуулахын чухлыг дурдсан байна. Шаардагдаж байгаа боловсрол мэдлэгийн сэдвийн хувьд оролцогчдын 36% нь бие даасан техникийн туслалцааг хүссэн бол 32% нь тухайн олон талт уулзалт өөрт нь мэдээлэл олгох боловсролын үйл ажиллагааг хүсэмжилсэн байна.
- Ихэнх оролцогчид олон талт уулзалтын бүлгийг **бие даасан байгууллага, эсвэл хариуцлагатай уул уурхайн төв** болон хөгжих хэрэгтэй хэмээн үзэж байна. Ярилцагчдын 27 хувь нь цаашид судалгаа эрхлэдэг, бодлогийн санал, санаачлагуудыг гаргадаг, олон нийтэд мэдээлэл түгээдэг төвийг хүсэж байна.
- Ярилцагчдын 50 хувь нь хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг тодорхойлсон **найман зарчмын хэсэг тус бүр дээрх стандартуудыг** гаргахыг санал болгон дэмжсэн.

Монгол улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, шинэ шатанд гаргахад энэхүү уулзалт нь өөрийн байр суурийг нэгэнт олжээ. Оролцогчид цаашид хийх ажлуудын

талаар маш олон санал гаргаж, өөрийн үйл ажиллагааг явуулах эрч хүчтэй байна. Гэсэн хэдий ч, тэдний үзэж байгаагаар олон талт уулзалтын хэтийн төлөв, алсын зорилгыг ойрын үед дахин тодорхойлох шаардлагатай байна. Урт хугацааны зорилготой байх нь хариуцлагатай уул уурхайн төлөөх үйл ажиллагаа явуулан, ололт амжилтад хүрэх боломжийг нээн өгөх болно.

## **II. ТАНИЛЦУУЛГА**

### **1. Өмнөх үг: Энэхүү үнэлгээг хэрхэн ашиглах вэ?**

Олон талууд оролцсон уулзалтын оролцогчид энэхүү үнэлгээний баримт бичгийг өөрсдийн үйл ажиллагаанд хэрэг болохуйц, ашигтай зүйл хэмээн үзнэ гэдэгт би найдаж байна. Оролцогчид цаашид энэхүү үнэлгээг үйл явцдаа удирдан чиглүүлэх зорилгоор ашиглан, цаашдын уулзалтууд болон үйл ажиллагааны агуулгын журмаар ашиглах байх гэдэгт мөн би найдаж байна. Үнэлгээ нь оролцогчдын өөрсдийнх нь өгсөн мэдээлэл дээр үндэслэгдэн хийгдсэн бөгөөд тэдгээр мэдээллийг та бүхэнд туслах, дэмжих зорилгоор нэгтгэн дүгнэж 1) үйл явцыг улам сайжруулснаар хамтын ажиллагааны хүчирхэг, эрүүл үр дүнтэй үндэс суурь болгох, болон 2) өөрсдийн саналыг ангилан цэгцэлж цаашдын үйл ажиллагааны эх үүсвэр болгох зорилгоор ашиглах эх үүсвэр болгох зорилгоор бүтээгдсэн болно.

Оролцогчдоос би III болон IV хэсгүүдэд анхаарлаа хандуулж энэхүү үйл явцад оролцсон өөрсдийн хамтрагч нарын санал, бодлыг бүрэн ойлгоосой хэмээн хүсэж байна. Улмаар олон талт уулзалтын оролцогчид нь энэхүү тайланг хянан, хэлэлцэж мөн тайланг хэрхэн ашиглах талаараа харилцан ярилцаж, хэлэлцэхийг хүсэж байна. Хэлэлцүүлэг өрнүүлсний дараагаар, энэхүү тайланг цаашид ашиглан ялангуяа жишээнүүд болон Хавсралт дээрх хэсэгт онцгой анхааралтайгаар хандан байнга үр өгөөжтэйгээр хэрэглэхийг хүсэмжилж байна.

– Алдер Коварик

### **2. Түүхэн үндэслэл**

Монгол улсад Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх олон талт уулзалт явц нь анх 2006 оны 11 дүгээр сард АНУ-ын Азийн сангийн (цаашид Азийн сан гэх) Монгол дахь салбараас Хариуцлагатай уул уурхайн асуудлаар дугуй ширээний хэлэлцүүлэг явуулснаар эхэлсэн юм. Энэхүү дугуй ширээний хэлэлцүүлгийг Азийн сангаас 2006 оны 9 дүгээр сард АНУ-д зохион байгуулсан судалгааны аялалд оролцон уул уурхайн салбар, үүний эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг судалсан оролцогч талуудын хүсэлтээр анхлан эхлүүлсэн түүхтэй. Анхны дугуй ширээний уулзалтад төрийн байгууллагууд, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл оролцон энэхүү олон талт уулзалтын үндэс суурийг тавьж байжээ. Эхний уулзалтаар оролцогчид өөрсдийн оролцооны дүрмийг батлан үүндээ оролцож буй бүх талуудаа харилцан хүндэлж байх заалтыг оруулсан байна. Цааш цаашдын уулзалтуудаар энэхүү дүрмийг дахин хянан үзэж, баталгаажуулсаар ирсэн түүхтэй. Олон талуудын уулзалт нь оролцогч талуудаар удирдан явагддаг бөгөөд Азийн сан нь дэмжлэг тусалцаа үзүүлэх, олон талт уулзалтын тэмдэглэл хөтлөгч болон нарийн бичгийн даргын үүрэгтэй үйл явц билээ. Азийн сан нь оролцогчдын хүсэлтээр энэхүү үйл явцыг зохион явуулах, хөтлөх болон нарийн бичгийн даргын үүргээ гүйцэтгэн ирсэн бөгөөд үүргийг гүйцэтгэхээр бүрэн баталгаажуулсаны

дараагаар Азийн сангийн зохион байгуулах үүрэг роль нь уулзалт тус бүр дээр баталгаажин, хангагдаж ирсэн байна.

2006 оны 11 дүгээр сараас хойш таван удаагийн нэгдсэн уулзалтыг хийгээд байна.



2006 оны аялын багийн оролцогчид Колорадогийн Хендерсон уурхайд зочилж буй нь.

стандартуудыг гаргах, хариуцлагатай уул уурхайн асуудлаар ажиллах байгууллага эсвэл төв үүсгэн байгуулах боломжыг судлах зорилготой ажлын хэсгийг дахин байгуулсан түүхтэй ажээ.

Энэхүү ажлын хэсэг нь Хариуцлагатай уул уурхайн талаарх тунхаглалыг гарган энэхүү баримт бичгийг харилцан ойлголцлын санамж бичиг болгон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийн төлөө гарын үсэг зуран нэгдэхийг олон нийтэд хандан уриалсан байна. Тунхаглалыг нэгдсэн бүлгийн хуралдаанаар 2007 оны 6 дугаар сард батлан гаргасан бөгөөд гарын үсэг зуран нэгдэн орох боломж нь хэнд ч нээлттэй хэвээр үлдсэн байна. Үүнээс гадна одоогийн ажлын хэсэг нь хариуцлагатай уул уурхайн асуудлыг 2015 оныг хүртэлх Эрдэс баялгийн салбарын стратегид багтаах, олон талын оролцоот үйл явц, хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт болон тунхаглалын талаар ард иргэдэд мэдээлэл, олон нийтийн мэдээллийн үйл ажиллагаа явуулах зэрэг олон төрөл бодлогийн асуудлаар ахиц дэвшил гаргахаар ажиллаж байна.

2006 оны 12 дугаар сарын эхээр Нидерландын вант улсын элчин сайдын яамнаас Азийн санд Ирээдүйгээ баталгаажуулах нь хөтөлбөрийн тэтгэлэгийг олгожээ. Ирээдүйгээ баталгаажуулах нь хэмээх энэхүү хөтөлбөр нь нийт долоон бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх бөгөөд үүний нэг нь олон талын оролцоот үйл явцыг дэмжих явдал юм. Ирээдүйгээ баталгаажуулах нь хөтөлбөр гурван жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд 2009 оны 12 дугаар сард дуусах юм. Ирээдүйгээ баталгаажуулах нь хөтөлбөрийн төсвөөс нийт гурван зуун гучин зургаан мянган (\$336,000) ам.долларыг олон талт үйл явцаар дамжуулан хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйл явцад

#### Уулзалтуудын ирц, оролцоо

Уулзалт I (Дугуй ширээний) - 35 оролцогч  
Уулзалт II- 70 оролцогч  
Уулзалт III- 60 оролцогч  
Уулзалт IV- 50 оролцогч  
Уулзалт V- 55 оролцогч

#### Бусад мэдээлэл

Тодорхойлолт болон зарчмууд -51 хүлээн зөвшөөрсөн гарын үсэг  
Тунхаглал- Одоогийн байдлаар 48 гарын үсэг  
Нийт оролцсон байгууллагуудын тоо- 30  
Байнгын оролцогч- 80  
Одоогийн байдлаарх нийт оролцогчид - 120

зарцуулахаар хуваарьласан байна. Энэхүү санхүүжилтийг уулзалтуудыг зохион байгуулах, олон талт уулзалтын үйл явцад техникийн туслалцаа үзүүлэх, олон талт уулзалтын үйл ажиллагаанд санхүүгийн тэтгэлэг олгох, судалгааны аялал зохион байгуулах, судалгаа болон дүн шинжилгээ хийх зэрэгт зарцуулаад байна.

***Хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт***

Бүх оролцогч талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурлаж, хууль сахиx ёсыг дээдэлсэн, Монгол улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг хариуцлагатай уул уурхай гэнэ.

***Хариуцлагатай уул уурхайн зарчмууд***

- олон талын оролцоог хангах,
- ил тод нээлттэй байх,
- хуулийг сахин дээдлэх,
- байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх,
- ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах,
- үр өгөөжтэй байх,
- хүмүүнлэг ёс зүйтэй байх,
- дэвшилтэт технологид суурилсан байх.

### ***3. Үнэлгээний зорилго***

Энэхүү судалгааны үйл ажиллагааны зорилго нь олон талт уулзалтын үйл явцыг оролцогчдын зүгээс, тэдний үзэл бодлын үүднээс үнэлэн тухайн үйл явцын ирээдүйг тодорхойлон мэдээлэх явдал юм. Үнэлгээ нь үйл явцын давуу болон сул талууд, үүнээс гарах үр дүнг нээн илрүүлж, энэхүү үйл явц нь өөрчлөгдөн, ахиц дэвшил гарах бүрд хэрэглэгдэх нөөц, эх үүсвэрүүдийг тогтоохыг эрэлхийлсэн болно.

Азийн сангаас энэхүү үнэлгээг 1) оролцогчдод үйл явцын цаашдын чиглэлийг тогтооход туслах, 2) оролцогчдын зүгээс энэхүү үйл явцын ахиц, дэвшлийн талаарх мониторингийн мэдээлэл цуглуулах, болон 3) Нидерландын вант улсын элчин сайдын яаманд төслийн талаарх мэдээлэх гэсэн 3 зорилгоор энэхүү гүйцэтгүүлсэн болно.

Үнэлгээг Азийн сангийн хамт олонтой хамтран Тафтс их сургуулийн Флетчерийн сургуулийн Алдер Коварик гүйцэтгэсэн болно. Слаусон сангаас (Slawson Foundation) Азийн сангийн зуны хамтрагчид хөтөлбөрөөр дамжуулан Алдер Коварикыг санхүүжүүлсэн юм. Энэхүү үнэлгээ буюу судалгааны үйл ажиллагаа нь цаашид Алдер Коварикын магистрын зэрэг хамгаалах ажилд тусгалаа олох боловч үнэлгээг гүйцэтгэхдээ өөрийнх нь анхны зорилгоос хазайлгүйгээр үндсэн зорилгод нь нийцүүлэн гүйцэтгэсэн болно.

### ***4. Үнэлгээний арга зүй***

Үнэлгээний мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа нь хагас бүтэц бүхий ярилцлагын аргаар явагдсан. Ярилцлага хийхдээ урьдчилан төлөвлөсөн үзэл баримтлалд тохируулан явуулж, оролцогч тэргүүлсэн үйл явц болгон уян хатан байдлаар явууллаа. Ярилцлагад хамрагдсaдын нууцыг хадгалахын хажуугаар, энэхүү тайлан нь

ярилцагчдын өөрсдийнх нь хэлсэн үг, илэрхийлсэн үзэл бодлыг бүрэн тусгахыг хичээсэн юм.

Судлаач нь нийт олон талт уулзалтын 22 оролцогчидтой уулзан ярилцлага хийсэн бөгөөд энэ нь барагцаалбал уулзалтуудын байнгын оролцогчдын 28% болж байна. Ярилцлагад хамрагдсан 22 хүн нь нийт 16 байгууллагыг төлөөлсөн ба төслийн нийт хугацаанд оролцсон нийт бүлгийн 50% орчмыг төлөөлж байсан. Нэгдсэн бүлгийн хуралдаанд оролцсон бүх талуудын буюу төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон бизнес эрхлэгчид зэрэг бүх төлөөллийг ярилцлагад татан оролцуулахын тулд боломжтой бүх арга хэмжээг авсан болно. Ярилцагчдыг сонгон авсан нь санамсаргүй түүвэрлэлт биш, харин оролцогчдын цаг зав болон тэдний боломжоос шалтгаалсан юм.

#### **Ярилцлагын үзэл баримтлал**

- *Үйл явцын давуу болон сул талууд*
- *Өнөөдрийг хүртэл явуулсан үйл ажиллагааны давуу болон сул талууд*
- *Ойрын хугацааны ирээдүйн үйл ажиллагаа болон нөөц эх үүсвэрүүд/шаардагдаж буй судалгаанууд*
- *Урт хугацааны зорилт болон нөөц эх үүсвэрүүд/ шаардагдаж буй судалгаанууд*

Ярилцлагыг Монгол хэл дээр хийж Англи хэл рүү орчуулан гүйцэтгэсэн болно.

#### **Ярилцлагад хамрагдагсад**

*1 эрдэмтэн*

*4 уул уурхайн компанийн төлөөлөл*

*8 төрийн байгууллагын төлөөлөл*

*9 иргэний нийгмийн төлөөлөл*

Ярилцагчдын хэлсэн үгс нь тэдний хэлснийг үгчлэн буулгаагүй байж болох бөгөөд үүний учир нь эхний шатанд Монголоос Англи хэлэнд аман хэлбэрээр орчуулагдан, улмаар энэхүү илтгэлд зориулан Монгол хэлэнд эргэн орчуулагдсанд оршино. Ямар ч тохиолдолд ярилцлагад

хамрагдагсдын хэлсэн үг болон санаа нь бүрэн хадгалагдсан бөгөөд хамгийн боломжит байдлаар үнэн зөв орчуулагдсан болно.

### **III. ОЛОН ТАЛЫН ОРОЛЦОГЧДЫН УУЛЗАЛТЫН ҮЙЛ ЯВЦЫН ТАЛААРХ САНАЛ БОДОЛ**

Оролцогчдоос нийт үйл явцын давуу болон сул талуудын талаар болон одоогоор гараад байгаа үр дүнгийн талаар асуулаа. Үйл явцын чиг хандлага болон энэ нь хэрхэн үүсэн бий болсон талаарх асуудал нь гарц, үр дүнгийн талаарх санал бодлоос өөр зүйл тул үйл явц болон үүний үр дүнгийн талаарх санал бодлуудыг энэхүү тайланд тусд нь тусгасан болно. Гол олсон мэдээлэл болгон нь түүнийг дэмжиж байгаа, эсэргүүцэж байгаа оролцогчын үзэл бодлыг бичлэг байдлаар тусгасан.

#### **1. Үйл явцын хэрэгжилт болон сул талууд**

- ✓ **Үйл явцыг нийтэд нь амжилттай болсон хэмээн дүгнэлээ**

Ярилцлагад оролцсон хүмүүсийн олонх нь (82% буюу нийт хүмүүсийн 18 нь) үйл явцын аргачлал, үйл явц болон ахиц дэвшилд сэтгэл ханамжтай байгаагаа дурджээ. Хоёр оролцогч энэхүү үйл явцад нийтэд нь сэтгэл хангалуун бус байгаагаа дурдсан ба харин өөр хоёр хүн үйл явцын талаарх дүгнэлт хараахан хийгээгүй гэж илэрхийлсэн. Бүх салбарын оролцогчид 2006 оны 11 дүгээр сард болсон эхний уулзалтаас хойш гарсан ахиц дэвшил нь маш гайхалтай байсныг цохон тэмдэглэсэн. Нэгэн оролцогч,



*Олон талт уулзалтанд оролцохоос өмнө бид уул уурхайн салбарын учруулж буй сөрөг нөлөөнд хариу өгөх цорын ганц арга нь төр болон уул уурхайн компаниудтай сөргөлдөж, мөргөлдөөн үүсгэх явдал хэмээн үзэж байлаа. Харилцан ярилцсаны хүчинд бид уул уурхайн компаниуд хэрхэн олон нийттэй хамтран ажиллаж болдогийг, бид хэрхэн уул уурхайн компаниудтай үр дүнтэйгээр ажиллаж болохыг ойлголоо.*

*“Олон талын оролцоот үйл явц нь хариуцлагатай уул уурхайн чиглэлд томоохон алхам хийх боломжийг олголоо.”*

“Талууд хоорондоо харилцан сөргөлцсөн байдлаас бие биенийгээ хүндэтгэн сонсож, харилцан ярих боллоо” хэмээн хэлж байлаа. Дор хаяад 6 оролцогч (Ярилцлагад оролцогчдын 27%) тайлбарлахдаа төр, иргэний нийгэм, уул уурхайн салбарын төлөөлөл хамтдаа суугаад хамтран ажиллаж, хэлэлцэж байгаа үйл явцын нэгээхэн хэсэг байсандаа ихээхэн бахархаж байгаагаа дурдсан байна. Гурван оролцогч

(Ярилцлагад оролцогчдын 14%) хэлэхдээ олон талын оролцоот үйл явц нь Монгол улсын хувьд яг цагаа олж болсон бөгөөд тулгараад байгаа бодит хэрэгцээнд тулгуурлажээ. Нэг оролцогчийн хэлснээр олон талын оролцоот үйл явцын оролцогчдын дунд одоог хүртэл үл итгэх байдал оршсоор байгаа ч хамтран ажиллан, хэлэлцсэнээр буруу мэдээлэл болон үндэслэлгүй сэжиглэх явдлыг бууруулсан байна.

✓ **Харилцан яриа болон хамтын ажиллагааг өндрөөр үнэлж байна**

12 оролцогчоос өгсөн саналаас үзвэл (55%) олон талт уулзалтын үйл явцын хэсэг болох уулзалтууд болон бусад үйл явдлын үеэр харилцан ярилцаж, санал бодлоо солилцох сайхан боломж гарсан хэмээн үзсэн байна. Маш олон хүн, “Хэлэлцэж, ярилцах нь хариуцлагатай уул

уурхайн асуудлаар хэрэгжих зөвшилцөлд хүрэхийн эхлэл” хэмээн хэлсэн нэгэн оролцогчийн хэлсэнтэй санаа нэгтэй байлаа. Хэд хэдэн оролцогч олон талт уулзалтыг үнэлж байгаагаа хэлсэн бөгөөд үүний учир нь тэд өөр

*“Би хэзээ ч боломж гарч уулзахгүй байсан хүмүүстэй уулзаж, харилцан ярилцаж, хамтран ажиллах боломжийг уулзалтууд олголоо. Бидний яриа, хэлэлцүүлэг нь тухайн асуудлыг бусад хүмүүсийн үзэл бодлын үүднээс ойлгоход тус болж ингэснээр намайг өөрийн ажлаа хийх боломжийг олгосон. Би хамтран ажиллах болон харилцан ярилцах илүү олон боломжуудыг хүсэж байна.”*

*“Тэгш оролцоо бол хамгийн чухал нь бөгөөд ингэснээр л хүмүүс өөрсдийн үл итгэх байдал, буруу ойлголтоос салж чадна.”*

бусад байгууллагуудын төлөөлөлтэй ижил тэгш эрхтэйгээр оролцох нийтийн форумыг бий болгон өгсөнд оршиж байна. Гурван оролцогчийн хэлснээр цаашид албан болон албан бусаар уулзалтууд болон албан бус бусад арга хэмжээний үеэр ч ярилцах, хэлэлцэх, хамтран ажиллахад тэд дуртай байх ажээ. Энэхүү санал бодлуудын эсрэг хоёр ярилцагч сөрөг санал өгсөн бөгөөд тэд хэлэхдээ сэтгэл хөдлөл болон мэдээлэлгүй байж гаргасан санал нь харилцан хэлэлцэх үйл явцад сөргөөр нөлөөлж байсан гэжээ.

✓ **Азийн сангийн үүрэг роль, дэмжлэг болон зохион байгуулалтын удирдлага**

*“Энэхүү үйл явц нь гайхамшигтай хүндлэл, хичээл зүтгэл болон мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулагдсан.”*

*“Азийн сангүйгээр энэ гурван талыг нэг ширээнд суулган бие биеэ хүндлэн ярилцах, санал бодлоо солилцох боломж олдохгүй байх байсан. Үйл явцад оролцож буй бүлэг нь нөөц эх үүсвэр болон эрх мэдлийн ялгаа байсан ч миний оролцоог бусдын адил ижил түвшинд хүлээн авч байсан.”*

Үйл явцын давуу талуудын талаар ерөнхийлөн асуухад, 11 хүн (50%) энэхүү үйл явцын нэгэн давуу тал нь

Азийн сангийн үүрэг роль болон үйл явцыг зохион байгуулсан байдал хэмээн хэлжээ. "Энэхүү үйл явцыг удирдахад Азийн сан нь яг тохирох бөгөөд уулзалтуудыг маш сайн зохион байгуулж, удирдсан" хэмээн нэгэн ярилцагч хэлсэн ба үүний хажуугаар хэд хэдэн ярилцагч байнгын ажиллагаатай ажлын хэсэг үүсгэн улмаар өөрийн үйл ажиллагаагаа нэгдсэн олон талт уулзалтын бүлэгт тайлагнаж байсан энэхүү хэлбэр нь ихээхэн таалагдсаныг дурджээ. Гэсэн хэдий ч, ярилцагчдын хоёр нь ажлын хэсгүүд нэгдсэн бүлэгт тайлагнахдаа өөрсдийн үйл ажиллагаагаа сайжруулах, ингэснээр нэгдсэн олон талт уулзалтын бүлэг нь ажлын хэсгийн шийдвэр болон зөвлөмжүүдийн цаад утгыг ойлгоход хэрэгтэй болохыг сануулсан байна.

✓ **Уул уурхайн компаниудаас илүү их төлөөлөл багтаах талаарх хүсэлт**

Долоон ярилцагч (32%) үзэхдээ уул уурхайн компаниудаас илүү их төлөөлөл оролцуулсан бол энэхүү үйл явцыг илүү сайжруулж болох байжээ. Сонирхолтой нь уул уурхайн салбараас оролцсон нэг оролцогч үүнийг хэлсэн бөгөөд үүний хажуугаар төрийн байгууллагын болон төрийн бус байгууллагын тус бүр 3 төлөөлөгч үүнийг бас цохон дурдсан байна. Эдгээр оролцогчид Монголын үндэсний уул уурхайн ассоциаци нь олон тооны уул уурхайн компаниудыг төлөөлж байгааг ойлгон энэхүү олон талт уулзалтын үйл явцад МУУҮА идэвхтэй оролцсонд талархал илэрхийлж байв. Гэхдээ зарим ярилцагчийн хэлснээр МУУҮА-д хамаардаг компаниуд нь бүрэн төгс төлөөлөл биш бөгөөд үйл явц нь бизнесийн олон төлөөлөл болон оролцооноос олон ургалч үзэл бодлыг оруулж, санал бодлыг нь авч байсан бол сайн байх байжээ. Мөн хэд хэдэн оролцогч уул уурхайн компаниуд нь хариуцлагатай уул уурхайг хэрэгжүүлэх хамгийн гол хэсэг тул тэд энэхүү олон талын оролцоот үйл явцад өөрсдийн саналаар оролцох нь чухал гэдгийг онцлон дурдсан. Уул уурхайн компаниудаас нэмэлт оролцогчид оролцсон тохиолдолд хариуцлагатай уул уурхайг хэрэгжүүлэхэд уул уурхайн компаниудад тулгараад байгаа сорилтууд болон хоёрдмол байдлыг сайтар ойлгоход тустай байх байсан хэмээн үзжээ.

**2. Бүтээгдэхүүний давуу талууд болон тулгараад буй сорилтууд**

✓ **Тодорхойлолт болон тунхаглал нь үйл явцын ихээхэн чухал үндэс суурийг бий болгосон**

Ерөнхийдөө оролцогчид үйл явцаас гарсан гол бүтээгдэхүүн болох Хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт, зарчмууд мөн тунхаг зэрэгт сэтгэл ханамжтай байна. Нэг оролцогч "Тодорхойлолт болон зарчмууд нь олон талын оролцоот үйл явц нь хэрхэн хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх талаар харилцан ярилцаж эхлэх, харилцан ойлголцох нэгдмэл нэг хэлийг бий болгосон" хэмээн хэлж байлаа. Таван оролцогч хэлэхдээ тунхагт гарын үсэг зурсан нь ихээхэн чухал бөгөөд энэ нь олон талт уулзалтын нэгэн чухал алхам байсныг дурдсан байна. Оролцогчид энэхүү үйл явдалд баяртай байгаагаа илэрхийлцгээсэн байна.

Хэдийгээр дийлэнх олонх биш ч гэсэн, хэд хэдэн оролцогчид тодорхойлолт болон зарчмуудад сэтгэл хангалуун байгаа ч, бүрэн хэмжээгээр сэтгэл хангалуун гэж үзэхгүй байгаагаа илэрхийлсэн. Эдгээр оролцогчид цохон тэмдэглэхдээ магадгүй бүрэн хэмжээгээр сэтгэл хангалуун бус байгаа нь сайн зүйл байж болох юм, учир нь энэ олон талуудын санаа бодлыг агуулсан зүйл учраас заавал бүгдийн санаанд нийцсэн байдалтай байх ёсгүй хэмээн хэлж байв. Нэг оролцогч хэдийгээр бүлэг одоогоор нэг

нэгдсэн хэлээр ярьж байгаа боловч харин нэгдсэн ойлголт дутуу ингэснээр хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдаж магад хэмээн сануулсан.

Тодорхойлолтын давуу тал нь оролцогчид үүнийг ашиглаж байгаагаас харагдаж болно. Иргэний нийгмийг төлөөлөн оролцогчид тодорхойлолт болон зарчмуудыг орон нутгийн санаачлагууд болох орон нутгийн боловсролын хөгжлийн хөтөлбөрт оруулах зэрэгт ашиглах боломжуудын талаар дурдаж байв. Үүн дээр нэмээд, уул уурхайн салбар нь энэхүү тодорхойлолтыг өөрийн олон нийтийн харилцааны зорилгоор ашиглах болжээ. Тиймээс энэхүү тодорхойлолт нь орон нутгийн болон үндэсний хэмжээний бодлогийн хэмжээнд нөлөөллийн түвшинд ашиглагдаад амжсан байна.

#### ✓ *Үйл ажиллагаа болон асуудал шийдвэрлэх шаардлагатай*

10 оролцогч (45%) олон талын оролцогчдын уулзалтын бүлэг нь хангалттай үйл ажиллагаа явуулаагүй, хангалттай бүтээгдэхүүн байхгүй, асуудал шийдээгүй хэмээн үзсэн байна. Нэг оролцогчийн хэлснээр одоогоор бүх ажил зөвхөн цаасан дээр байна. Ярилцлагын үеэр богино хугацааны ялалт болон бодитой ажил хэрэг шаардлагатай байгааг дурдсан нь эдгээр хүмүүсийн санал бодлыг харуулж байна. Асуудлыг шийдвэрлэж эхэлснээр Монгол улсад хариуцлагатай уул уурхайг хэрхэн хэрэгжүүлэх талаар эерэг жишээг бий болгох ажээ. Оролцогчдын саналд нэн даруй үйл ажиллагаа явуулахыг шаардсан өнгө аяс илэрч байгаа нь хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаа нь байгаль орчин нийгмийн сөрөг үзэгдлүүдийг үүсгээд эхэлсэн тул энэхүү саналаа илэрхийлж байсан.

*“Үйл явц нь одоогоор удаан, нэг газар дээрээ л байгаад байна, тиймээс би үүнийг ямар ч үр дүнгүй бас нэг баримт бичиг битгий болоосой л гэж хүсэж байна.”*

*“Үйл явц нь урагшилж, ахиц гарч байна, гэхдээ олон талт уулзалт нь одоо жинхэнэ ажлаа эхлэх цаг болсон.”*

Ойрын хугацааны үйл ажиллагаа болон асуудал шийдвэрлэх нь нэн чухал хэдий боловч 3 оролцогч үйл явцыг удаан алгуурхан явах хэрэгтэй гэж санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Эдгээр хүмүүс нь хэрэв үйл явц хэт хурдтай үргэлжилсэн тохиолдолд оролцогчдын дунд үл ойлголцох, харилцан зөвшөөрөхгүй байх байдал үүсэж мэднэ хэмээн болгоомжилсон байна.

Найман оролцогчийн (36%) тодорхойлсноор ойрын хугацааны гол үйл ажиллагаа нь 2015 оныг хүртэлх Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх стратегид хариуцлагатай уул уурхайн асуудлыг багтаах явдал байлаа. Оролцогчдын үзэж байгаагаар энэхүү албан ёсны төрийн баримт бичигт хариуцлагатай уул уурхайн үзэл баримтлалыг оруулах нь олон талт уулзалт цаашид үйл ажиллагаагаа явуулах хууль зүйн үндэс суурийг тавина хэмээн үзжээ. “2015 оныг хүртэлх Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх стратегид хариуцлагатай уул уурхайн асуудлыг багтаах нь ирээдүйд оруулж буй хөрөнгө оруулалт бөгөөд бүхэлдээ маш их чухал үйл явц юм” хэмээн нэгэн оролцогч хэлжээ.

#### **IV. ЦААШДЫН ЧИГЛЭЛ – ДАРАА НЬ ЯАХ ВЭ?**

Оролцогчдоос олон талт хэлэлцүүлгийн ойрын болон урт хугацааны зорилгын талаар асуулаа. Үйл явцын ирээдүйн талаар хэлэлцэж байхдаа оролцогчид ямар нөөц эх үүсвэрийг ашиглан өөрсдийн зорилгод хүрч болохыг мөн хэлэлцсэн юм. Энэхүү хэсэг

нь 1) олон талт уулзалтын үйл явцын цаашдын хэтийн төлөвт тохирсон үйл явцын саналуудыг гаргах, болон 2) оролцогчид цаашид ямар үйл ажиллагаа явуулах талаар саналаа гаргах гэсэн байдлаар асуулт авахаар төлөвлөгдсөн байв. Дараагийн V хэсэг нь улам гүнзгийрүүлэн дараа нь юу хийх вэ хэмээх асуултыг агуулсан бөгөөд ингэснээр оролцогчид хариуцлагатай уул уурхайг Монголд хөгжүүлэхэд хэрэглэх хэд хэдэн зөвлөлдөх асуудлуудыг гарган тавих боломжийг олгосон юм. Үүний хүрээнд, оролцогчдод шаардагдах нөөц эх үүсвэрийг нь танилцуулж, судалгааны материалуудыг холбоос хийх болон хавсаргах байдлаар өгсөн. Цаг хугацааны асуудлаас шалтгаалан, бүх оролцогчдын хүссэн мэдээлэл авах хүсэлтийг биелүүлж чадаагүй болно. Үүнээс гадна, хэд хэдэн нөөц, эх үүсвэрийг орчуулаагүй бөгөөд цаашид олон талын оролцоот үйл явц өөрөө тэдгээрийг орчуулах хэрэгтэй эсэхийг шийдвэрлэх хэрэгтэй болно.

**1. Олон талт хэлэлцүүлэг нь Монгол улсын хариуцлагатай уул уурхайн хөгжилд хэрхэн тус нэмэр болох асуудалд анхаарах хамгийн чухал цаг үе**

Ихэнх оролцогчдын үзэж байгаагаар Монгол улсад хариуцлагатай уул уурхайг сурталчлах нь олон талт уулзалтын үндсэн чиглэл хэмээн үзэж байв. Гэхдээ оролцогчдын хооронд бага зэргийн ялгаа гарсан нь талуудын уулзалтын тусгайлсан зорилго, эдгээр зорилгодоо хүрэхэд ямар стратеги, хандлагууд хамгийн чухал байх вэ гэдэг асуудал дээр байсан юм.

Оролцогчид өөрийн үгэндээ “олон талт хэлэлцүүлэг нь тодорхойлолтыг бий болгосноор байшин барьсан ч гэсэн нийт зорилгоо тодорхойлоогүй тул байшингийн суурь нь дутуу байна,” хэмээн дурджээ. Тэд “Бид олон талт хэлэлцүүлэг хэрхэн хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх жишээ нь төрийн зохицуулалтад хандах болон өөр аргуудаар хөгжүүлэх вэ гэдэг дээр анхаарах ёстой” гэх хэлж байв.

*“Мастер төлөвлөгөө эсвэл 15 жилийн төлвийг боловсруулан гаргах хэрэгтэй. Энэхүү баримтад ирээдүйд бие даасан хууль ёсны байгууллага байгуулах талаар дурдах хэрэгтэй ба мөн бидний хариуцлагатай уул уурхайг бий болгох зорилгын хүрээнд хийгдэх бодит үе шатуудыг тусгасан ажлын төлөвлөгөө мөн гарах хэрэгтэй. Одоогоор бид хамгийн чухал дараагын алхам юу болох вэ гэдэг дээр бүрэн итгэлгүй байна.”*

*“Энэ талаар бид бага зэрэг хойшоо яваад байна, учир нь бид Монголд тулгараад байгаа хамгийн чухал асуудлыг эхэлж тогтоолгүйгээр шийдлийг нь санал болгоод байна.”*

Үйл явцын ирээдүйн чиглэлийн тухай асуухад, оролцогчдын тал нь тухайн бүлэг өсөн хөгжиж, ерөнхий стратеги төлөвлөлтөө хийх нь чухал гэж үзжээ.

*“Олон талын оролцоот үйл явц нь хууль ёсны байгууллага болох, зорилго тодорхойлох, төслүүд дээр ажиллах зэрэг хэд хэдэн салбарт зэрэгцэн ажиллах хэрэгтэй байна.”*

*“Хэтийн зорилго болон түүнд хүрэх алхамуудыг тогтоох зайлшгүй шаардлагатай”*

Үүн дээр нэмээд оролцогчдын хагасаас арай цөөн хэсэг нь үйл ажиллагааны төлөвлөгөө гаргахын чухлыг дурдсан байна. Стратеги болон ажлын төлөвлөгөөний саналуудын дотор ихэнх оролцогчид эдгээр үйл явцыг олон талт хэлэлцүүлэг уулзалт нь бие даасан байгууллага эсвэл төв болох үйл явцын хүрээнд хийгдэх ёстой хэмээн үзэж байна.

Оролцогчид үйл ажиллагаагаа төвлөрүүлэн хандуулах тусгайлсан асуудлуудын талаар олон саналтай байж харин тэднээс ойрын болон урт хугацааны стратегийн талаар

асуухад олон талт уулзалтын үйл явцын үйл ажиллагааг ойрын үед тусгайлсан үйл ажиллагаа нь хэрхэн сайжруулж болох талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй байсан. Нэгдсэн нэг стратегийн алсын хараа дутагдалтайгаас зарим оролцогч хэрхэн хамгийн сайнаар хариуцлагатай уул уурхайд хувь нэмэр оруулах болон дараагийн удаад ямар үйл ажиллагааг явуулах талаар бүрэн итгэлгүй байцгаасан. Оролцогчид хариуцлагатай уул уурхайг бодит байдлаар нь хэрэгжүүлэх нь маш олон талын үйл ажиллагааг шаардах ажил гэдэгт бүгд санаа нэгдсэн. Монгол улсад хариуцлагатай уул уурхай байдаг хэмээн хэлэх хүртэл их цаг хугацаа, болон нөөц эх үүсвэрүүд шаардагдана. Гэсэн хэдий ч оролцогчдын онцлог үйл ажиллагааны талаар гаргасан олон тооны санал дээр үндэслэн, үүнийг баримт болгон үзэхэд, бүлгийн хувьд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд ашиглан үйл ажиллагаа явуулж болох хэд хэдэн зүйл байна. Одоогоор олон талт хэлэлцүүлэг уулзалт хамгийн ихээр анхаарлаа хандуулах шаардагатай салбарыг тогтоох, ингэснээр олон талууд нь өөр өөрсдийн онцлог байр суурь, хүчин чадал болон нөөц эх үүсвэрийг ашиглан хариуцлагатай уул уурхайг урагшлуулах талаар ойлголцох хамгийн чухал цаг ирээд байгаа ажээ.

Хэрэв бүлэг нь нэгдсэн зорилго, стратеги боловсруулах, эсвэл асуудлуудыг зэрэглэх зэрэг сорилтуудад анхаарлаа хандуулахаар сонгон авсан тохиолдолд, сонгогдсон зохион байгуулагч нь олон талт хэлэлцүүлэг уулзалтын ирээдүйг төлөвлөх, алсыг харах, стратеги төлөвлөлт хийх, үйл явцуудыг ангилан дугаарлах зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан гардан зохион байгуулж болно. Стратеги төлөвлөлт болон асуудлуудыг ангилан дугаарлах олон тооны аргачлал байх бөгөөд энд нэгэн жижиг жишээг харууллаа. Эдгээр жишээнүүд нь ашиглаж болох **үйл явцыг** харуулах боловч харин **агуулгыг** тогтоохгүй болохыг санаарай.

#### **Хувилбар 1**

**Зорилго:** Ирээдүйн талаар дэлгэрэнгүй зураглал боловсруулах

*Удирдагч нь бүлгийн энэхүү хэтийн төлөв тогтоох дасгалыг бүх дасгалын хугацаанд удирдана. Хэтийн төлвийг тогтоох гэдэг нь ирээдүйн ямар нэгэн хугацаанд магадгүй одоогоос 10-15 жилийн дараа зарим зүйлс хэрхэн, ямар байдалтай харагдаж байхыг тогтоох явдал юм. Энэхүү дасгал нь бүлэгт олон талын оролцоот үйл явц ирээдүйд ямар байдалтай харагдах, үүний үйл ажиллагааны үр дүнд ямар өөрчлөлтүүд гарсан байх талаар ерөнхий зураглал гаргахад туслана. Дэлгэрэнгүй зураглал болон хэтийн төлөв нь бүлгийг хүнд хэцүү цаг үед нэгтгэж, цаашид стратеги төлөвлөгөө хийх асуудлын ач холбогдлыг тогтоох, ирээдүй хүртэл жолоодох ажлын төлөвлөгөө гаргах зэрэгт туслалцаа үзүүлэх болно.*

*Монгол улс дахь хариуцлагатай уул уурхайн төлөөх олон талын оролцоот үйл явцын үнэлгээ*



**Хувилбар 2**

**Зорилго:** Логик хүрээлэл буюу зорилго, зорилтуудыг тодорхойлон бий болгосноор стратеги төлөвлөгөө боловсруулах нь

Бүлгээр ажиллан, логик хүрээлэл гаргахын тулд зорилго болон багц зорилгууд гарган үүний хүрээнд зорилтууд болон бүтээгдэхүүнийг агуулсан цогц хүрээлэл гаргадаг. Энэхүү логик хүрээллийг цаашид үйл ажиллагааны дараалал/төлөвлөгөө болгон ашиглаж болно. Ийм төрлийн үйл явцад ажлын хэсэг нь өөр өөрийн ажлын төлөвлөгөө гаргах бөгөөд тэд зорилт болгон дээр дэвшилт гаргахаар ажилладаг. Хэрэв бүрэн хэмжээний логик хүрээллийг гаргах нь хэтэрхий эрт бол бүлгээр ажиллан ойрын хугацаанд биелүүлэх, тулгараад байгаа асуудлыг ягаварлан цэгцэлж түүний дараагаар үүнийг логик хүрээлэлд хэрхэн тохирч байгааг нь харьцуулан хар, дараа нь үүнийг даган ажлын төлөвлөгөө гарга.

**Логик хүрээллийн хэлбэр**

<b>Нийт зорилго:</b> Ямар амжилтанд хүрэхийг хүсэж байна вэ?			
<b>Хариуцлагатай уул уурхайн төв/байгууллага нь ямар амжилт/үр дүн гаргах вэ?</b>			
<b>Тусгай зорилт</b> <i>Асуух:</i> Хүмүүсийн мэдлэг, хандлага болон зан үйлд ямар өөрчлөлт гаргахыг бид хүсэж байгаа вэ?	<b>Гол бүтээгдэхүүн</b> <i>Асуух:</i> Ямар бараа болон үйлчилгээг хангах вэ?	<b>Гол үйл ажиллагаа</b> <i>Асуух:</i> Өдөр тутмын ямар үйл ажиллагаа нь бидний бүтээгдэхүүнд нөлөөлөх вэ?	<b>Үзүүлэлт</b> <i>Асуух:</i> Өөрийнхөө зорилтод хүрсэнээ бид хэрхэн мэдэх билээ?
Зорилт 1- Анхаар: Бүх зорилтуудыг биелүүлснээр нийт зорилгод хувь нэмрээ оруулах уу?	Зорилт 1 ийг хангахад шаардлагатай бараа, үйлчилгээг жагсаа	Гол бүтээгдэхүүнийг бий болгох чиглэлд шууд хөтлөх гол үйл ажиллагааны жагсаалт гарга.	Зорилтод хүрэх ахиц дэвшил мөн хүлээгдэж байгаа үр дүн, нөлөөг хэмжих үзүүлэлтүүдийн жагсаалтыг гарга
Зорилт 2	Зорилт 2 бүтээгдэхүүн	Зорилт 2 үйл ажиллагаа	Зорилт 2 үзүүлэлт
Зорилт 3	Зорилт 3 бүтээгдэхүүн	Зорилт 3 үйл ажиллагаа	Зорилт 3 үзүүлэлт

Мерси Кор байгууллагийн Төлөвлөлт, Мониторинг болон Үнэлгээний Зааварчилгаанаас ашиглалаа, доорх холбоосоор орж дэлгэрэнгүйг үзнэ үү. [www.mercycorps.org/topics/civilsociety/1069](http://www.mercycorps.org/topics/civilsociety/1069)

**Хувилбар 3**

**Зорилго:** Дэс дараалал, ач холбогдлыг тогтоох үйл явц

Үйл ажиллагааны дэс дараалал, ач холбогдлыг тогтоох дасгал нь цагийн хязгаарлалт, нөөц эх үүсвэрийн дутагдал, үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах оролцогчдын боломж чадвар зэргээс хамаардаг. Ийм төрлийн хязгаарлалтын үед бүлгүүд тулгараад байгаа асуудлуудыг тодорхойлон, улмаар тэдгээрийг ач холбогдлоор нь дугаарлан (жишээ нь аль асуудал нь хамгийн муу нөлөөг үзүүлж байгаа гэх мэт) тэдгээр асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг мөн дугаарлан цэгцэлж болно (жишээ нь хуулийн хэрэгжилт дээр хамгийн эхэнд анхаарна гэх мэтээр). Бүлгийн хувьд, энэхүү дэс дараалал ач холбогдлыг тогтоох дасгал нь үйл ажиллагаа, тусгай үйл ажиллагааны санаа, зэргийг хүрч болохуйц тусгай шалгууруудын доор (жишээ нь техникийн байх, зардал багатай шийдэлтэй байх гэх мэт) ангилан ялгах, яагаад санал болгож байгаа үйл ажиллагаа нь чухал гэдгийг мэдэх нь зөв (жишээ нь ингэснээр их хэмжээгээр өвчин тархахыг бууруулах гэх мэт). Эдгээр үйл ажиллагааны нөөц эх үүсвэр болон үүнд үзүүлэх дэмжлэгийн жагсаалтыг гарган хэрэгжүүлж болохуйцаас нь эхлэн дугаарлан цэгцлэх хэрэгтэй. Үүний дараагаар энэхүү жагсаалтаа 1-2 жилийн үйл ажиллагааны хуваарьтаа багтаан шаардагдах цаг хугацаа болон ямар үр нөлөө хүлээгдэж байгааг бас жагсаа. Үүний дараагаар үйл ажиллагаа болгоныг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулж болно. Үйл ажиллагаануудыг дэс дараагаар нь жагсаах, ач холбогдлыг нь тогтоох өөр олон арга байдаг бөгөөд энэ бол зөвхөн нэг жишээ юм.

Хүрч болохуйц                      Хүрч Үл болохуйц

Чухал


Чухал бус

#### **Хувилбар 4**

##### **Зорилго:** Туршилтын төсөл

*Энэ нь нэг байрлал болон нэг асуудлаар тусгайлан төлөвлөсөн, богино хугацааны үйл ажиллагаа явуулах явдал юм. Үүнийг заавал өмнө нь гаргасан жагсаалтаас сонгох хэрэггүй бөгөөд харин бүлгийн дотор харилцан зөвшилцөж сонгосон байх хэрэгтэй. Тусгай нэгэн төсөл дээр ажиллана гэдэг нь олон төрөл сонголтыг бий болгон турших боломж олгон, бидний яриад байгаа төвийн зорилго болон зорилтуудыг тодорхойлоход өөрийн хувь нэмрээ оруулж болно. Жишээ нь бүлэг нь найман зарчмын нэгийг сонгон аваад ямар нэг уул уурхайн компани түүнийг дагаж мөрдөж байгаа эсэхийг тогтоох багц стандарт эсвэл шалгуурыг гаргаж болно. Эдгээр стандартуудыг гаргахдаа одоо хэрэглэж байгаа төрөөс тогтоосон стандартуудыг хэрэглэж болохоос гадна, зах зээлийн шаардлага, шинээр хийгдсэн судалгаа болон бие даасан техникийн экспертийн санал зэргийг тусгах нь зөв. Стандартууд нь хэд хэдэн компанийн үйл ажиллагаа болон олон нийт дээр туршигдан, хэрхэн болж өнгөрсөн талаар санал хүсэлтийг нь цуглуулах хэрэгтэй. Энэхүү туршилтын үйл явцаас ихээхэн зүйлийг сурч болох бөгөөд эдгээрийн бүрэн хэмжээний багц стандарт гарган хэрэгжүүлэх эсвэл олон талын оролцоот үйл явцын стратегийн төлөвлөгөөг гаргах зэрэг зорилгод ашиглаж болно.*

## **2. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх стратегийн жишээ**

Оролцогчдоос цаашид хэрэгжүүлэх шаардлагатай талаар хамгийн олон тоогоор дурдсан үйл ажиллагаа нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийн төлөөх боловсролын үйл ажиллагаа байсан бөгөөд үүгээр дамжуулан мэдээлэл, нөлөөллийн төв байгуулах эсвэл дээр өгүүлсэн найман зарчим болгон дээр тусгайлсан стандартыг гаргах үйл ажиллагаанууд багтсан байлаа. Оролцогчдын санал бодол нь маш олон төрөл байсан бөгөөд энэ нь мөн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, стратеги дээр ч гэсэн адил хэмжээнд байсан. Хариуцлагатай уул уурхайн стратегийг хэрэгжүүлэх олон тооны сонголт байна. Энэхүү хэсэг нь дээр өгөгдсөн бүлгүүд хэрхэн стратегийг санал болгох боловсруулах талаарх хэсгээс хамаагүй өөр болохыг анхаарна уу.

*“Ажлын хэсэг болон олон талт уулзалтын оролцогчид нь явуулах үйл ажиллагаан дээрээ сайтар зөвшилцөж, хамгийн өндөр үр дүнд хүрэхийн тулд маш нарийн төлөвлөж, ингэснээр хариуцлагатай уул уурхайн асуудал дээр амжилт гаргаж чадна..... Нарийвчилсан кейс судалгаа нь бидэнд бусдаас суралцах боломж олгоно”*

Олон тооны оролцогчид хариуцлагатай уул уурхайн асуудалд ахиц дэвшил гаргаж буй өөр бусад бүлгүүдийн жишээнээс хэлж өгөхийг хүссэн. Тэд чиг хандлага, хэтийн төлөв, бусад олон талын оролцоот бүлгүүдийн бүтэц, сайн дурын санаачлага болон засгийн газрын хөтөлбөрүүдийн талаар мэдэхийг хүсэж байв. Оролцогчид эдгээр мэдээллийг өөрсдийн цаашдын стратегийн талаар тунгаан бодох, хариуцлагатай уул уурхайн асуудлаар ажиллах төв бий болгоход ашиглана хэмээн хэлцгээж байсан.



**Хувилбарууд:** Хариуцлагатай уул уурхай болон хариуцлагатай бизнесийн практик дахь бусад хандлагуудаас суралцах нь

**“Ногоон алт” - Хариуцлагатай уул уурхайн сайн дурын гэрчилгээжүүлэлт**

Эдгээр санаачлагууд нь олборлолт явуулаагүй уул уурхайн компаниудыг боломжтой зах зээлтэй нь холбож өгдөг. Хариуцлагатайгаар олборлосон эрдэс баялагийг худалдан авах зах зээл байгаа гэдгийг батлах тодорхой баталгаа байгаа бөгөөд энэхүү зах зээлд нэвтрэхийн тулд компаниуд хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулдаг гэдгээ баталгаажуулах эсвэл өөр ямар нэгэн аргаар өөрсдийн үйл ажиллагааг хариуцлагатай хэмээн батлах хүсэлтэй байдаг.

**Уул уурхайн гэрчилгээжүүлэлтийн үнэлгээний төсөл нь** олон улсын хэмжээний гуравдагч талаар аудитыг хийлгэсний үндсэн дээр уул уурхайн компанийн нийгэм, эдийн засгийн асуудалд хандах үйл ажиллагааг үнэлэн гэрчилгээжүүлэх 3 жилийн хугацааны судалгааны төсөл байсан юм. Энэхүү тайлангийн Хавсралт 2-т төслийн талаар тойм баримтыг оруулсан бөгөөд тухайн төслийн олон талын оролцоот бүлгээс гаргасан стандартуудын Монгол орчуулгыг мөн хавсаргасан болно.

**Олон улсын уул уурхай, төмөрлөгийн зөвлөл (ОУУУТЗ)** нь уул уурхайн компаниудын үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх системийг хөгжүүлэх талаар ажиллаж буй бөгөөд энэхүү гэрчилгээ нь мөн тусгайлан гаргасан багц стандартуудын хүрээнд явагддаг. Одоогоор Рио Тинто болон ВНР Билитон компаниуд нь ОУУУТЗ-ийн гэрчилгээжүүлэлтэд хамрагдахаар хичээж, багц зарчмуудын дагуу өөрсдийн тайлангаа гаргаж байна. Энэхүү стандартыг нь ОУУУТЗ-ийн тогтвортой хөгжлийн зарчмууд хэмээн нэрлэдэг. Тайлангийн Хавсралт 3 дээр одоогийн ОУУУТЗ-ийн үйл ажиллагааны талаар цухас дурдаж, гэрчилгээжүүлэлтийн системийн талаар тайлбарласан.

**ISO 14001- Байгаль орчны удирдлагийн системийн сайн дурын стандарт**

ISO 14001 стандартууд нь олон тооны компаниудын хүлээн зөвшөөрч даган нэгдсэн сайн дурын стандартуудын багц бөгөөд энэхүү багц нь байгаль орчны удирдлагийн олон улсын хамгийн сайн практикыг агуулдаг. Айвенхоу Майнс компани ISO 14001 стандартыг даган мөрдөхөөр итгэмжлэгдсэн. Компаниуд нь мөн өөрсдийн сайн дураар гуравдагч талын гэрчилгээжүүлэлтийг хийлгэж болох бөгөөд үүгээр дамжуулан тэд ISO 14001 стандартуудыг даган мөрдөж байгаа эсэхээ баталгаажуулж болно. Энэхүү тайлангийн 4 дүгээр хавсралтад ISO системийн болон 14001 стандартуудын талаар мэдээлсэн болно.

**Австралийн уул уурхайн омбудсман - Маргаан таслах механизм**

Уул уурхайн омбудсман нь Австралийн уул уурхайн компаниудын үүсгэж байгаа хүний эрхийн талаарх зөрчил болон байгаль орчны доройтолтой холбоотой олон нийтийн санал бодол, гомдлыг тухайн компаниудтай зөвшилцсөний үндсэн дээр маргаан таслах этгээд юм. Олон нийтээс гаргасан гомдлыг тухайн газарт очин шалгаснаар баталгаажуулдаг бөгөөд энэхүү үйл ажиллагааг багц стандартын хүрээнд гүйцэтгэдэг. Тухайн гомдлыг баталгаажуулсаны дараагаар, уул уурхайн омбудсман нь олон нийт болон уул уурхайн компанийн хооронд харилцан яриаг өрнүүлэн, тухайн гомдолд хариулт өгдөг. Энэхүү тайлангийн 5 дугаар хавсралтад Уул уурхайн омбудсман болон үүнд хэрэглэдэг стандартуудын талаар оруулсан болно.

**Уул уурхайн мэдээллийн төв - Иссик куль, Киргизстан**

Олон нийт, бизнесийн форум хэмээх нэр бүхий нэгэн байгууллага Киргизстан улсын Иссик Куль хотод уул уурхайн мэдээллийн төвийг байгуулсан нь томоохон хэмжээний алтны уурхай болон түүний эргэн тойронд оршин сууж байгаа олон нийтийн хооронд үр дүнтэй хамтын ажиллагаа явуулах боломжийг олгосон байна. Олон нийт, бизнесийн форум нь бизнесийн байгууллага, төрийн болон иргэний нийгмийн оролцоо бүхий олон талын оролцоот үйл явцын нэг жишээ бөгөөд өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан бизнес эрхлэгчид болон олон нийтийн хоорондын мэдээллийн солилцоог сайжруулах үйл ажиллагаа явуулдагийн хүрээнд уул уурхайн мэдээллийн төв багтаж байна. Үүнээс гадна Олон нийт, бизнесийн форум нь байгаль орчны мониторинг болон байгаль хамгаалах үйл ажиллагааг явуулдаг. Энэхүү тайлангийн 6 дугаар хавсралтад Олон нийт, бизнесийн форумын үйл ажиллагаа болон бүтцийн талаар мэдээлсэн.

**Улс даяарх хариуцлагатай бренд - Камбодж улсын шударга хөдөлмөрийн бренд**

1999 онд Камбодж улсын Засгийн газраас бусад хөдөлмөрийн хууль болон хөдөлмөр эрхлэлтийн үйл явцыг сайжруулах зорилго бүхий хөтөлбөр хэрэгжүүлэхээр санаа нэгдэн зүтгэж эхэлжээ. Энэхүү хөтөлбөрийг Камбодж улсын худалдааны хамгийн том түнш болох АНУ, НҮБ-ын Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ), Камбоджын хөдөлмөрийн холбоо, Камбоджын аж үйлдвэрийн бүлэглэл болох Камбоджын бэлэн хувцас үйлдвэрлэгчдийн холбоод хамтран хэрэгжүүлж эхэлжээ. Хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөрийн хуулийг сайжруулан, боловсронгуй болгох, хөдөлмөрийн стандартыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх хүчтэй, чанд хатуу систем бий болгох зорилго тавьсан бөгөөд үүнийг ОУХБ-ын байнгын мониторингын хөтөлбөрт хамруулах зорилготой байсан байна. Оёмол бүтээгдэхүүн болон сүлжмэл эдлэлийн үйлдвэр нь хамгийн гол салбар байсан бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд хариуцлагатай хөдөлмөрийн практикыг бий болгож чадсанаар Камбодж улс нь өөрийн бэлэн хувцасны үйлдвэрлэлд өрсөлдөх давуу талаа тодорхойлсон юм. Gap болон Nike зэрэг компаниуд хариуцлагатай компаниуд хэмээн нэрлэгддэг болохын хувьд Камбоджид үйлдвэрээ байгуулахаар сонгон авснаар өөрсдийн нэр хүндээ алдахаас болгоомжилж байсан ч тэд хөдөлмөрийн үйл ажиллагаа, практикыг нээлттэй, ил тод олон нийтийн мониторингын хүрээнд баталгаажуулах болохыг мэдсэний дараагаар эргэлзээгээ арилгаж эхэлжээ. Энэхүү хөтөлбөрийн үр дүнд Камбодж улс нь өөрийн улсыг хариуцлагатай хөдөлмөрийн орон гэсэн "брендийг" бий болгосон бөгөөд энэ нь зарим талаар Монголд бий болж байгаа "Ногоон алт" брендтэй ижил төстэй юм.

### **3. Олон нийтийн оролцоо, боловсрол мэдлэг, мэдээлэл түгээлтийн олон түвшин шаардлагатай байна**

Олон оролцогчид нэмэлт мэдээлэл авч илүү мэдлэгтэй болохыг хүсч байлаа. Нийтдээ, 16 хүн (73%) тэд олон талт бүлгээс дараах зүйлсийг хүсэж байгаагаа хэлсэн байна. Үүнд:

- Олон нийтийг татан оруулах болон мэдээлэл түгээх үйл ажиллагаа явуулах; болон
- Уул уурхай, хариуцлагатай уул уурхайн талаар илүү их мэдээлэл олж авах.

Эдгээр боловсролын болон оролцооны үйл ажиллагаанууд нь оролцогчид богино хугацаанд хийж гүйцэтгэхийг санал болгож байсан ажлуудын нэг юм. Гэсэн хэдий ч оролцогчид эдгээр үйл ажиллагаануудыг дэс дугаарлан, ач холбогдлоор нь жагсаан улмаар *бүлэг* нь энэхүү үйл ажиллагаанд буюу хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд хэрхэн тус нэмэр болж гүйцэтгэж чадахаа тодорхойлохын хажуугаар үйл ажиллагааг нэгээхэн хэсэг нь болгон урт хугацааны төлөвлөгөө гаргахыг санал болгож байсан.

#### **✓ Олон нийтийн оролцоо**

15 ярилцагч (68%) хэлэхдээ иргэдийн оролцоо, тэдний мэдлэг болон мэдээлэл түгээх үйл ажиллагаа нь олон талт уулзалтын үйл ажиллагааны дараагийн үе шат хэмээн үзсэн байна. Нэг оролцогч “Олон талт хэлэлцүүлэг уулзалтаас мэдээлэл түгээгдэн хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд гол үүргийг гүйцэтгэж буй талуудад мэдээлэл хүрч байх нь зөв бөгөөд энэхүү талуудын тоонд уурхайнууд, орон нутгийн засаг захиргаа болон иргэд багтана” хэмээн хэлж байсан. Өөр нэг оролцогч тухайн асуудлыг “Уул уурхайн талаар ард иргэдэд маш их буруу ойлголт, буруу мэдээлэл байгаа” хэмээн тодорхойлсон.

*“Олон нийт хариуцлагатай уул уурхайг бий болгох боломжтой гэдгийг ойлгож үүнийг бий болгохын тулд бид хамтран ажиллах хэрэгтэй гэдгийг ойлгох шаардлагатай байна.”*

*“Уул уурхайн үйл ажиллагааны эрх болон хариуцлагийн талаар мэдээлэл олон нийтийн түвшинд дутагдалтай байна. Тиймээс иргэдийнхээ мэдлэгийн дээшлүүлэх, тэднийг хүчирхэгжүүлэх шаардлагатай байна.”*

*“Шийдвэр гаргалт нь ажлын хэсэг дээр гарч хийгдэж байгаа нь сайн боловч, үүнийг олон нийтийн түвшинд хүртэл хянаж шүүх хэрэгтэй байна.”*

*“Төр зөсэг болон олон нийтийн хооронд мэдээллийн хоосон орон зай байна. Хүмүүс уул уурхайн хууль, бодлогын талаар зөв, нээлттэй мэдээллийг авах эрхтэй тул олон талын оролцоот бүлэг нь энэхүү мэдээллийг түгээж болно.”*

*“Хариуцлагатай уул уурхай нь уурхайн бүх түвшинд шүүгдэн ажиллах ёстой ба үүний тоонд компаниуд олон нийттэй илүү үр дүнтэй хамтран ажиллах арга, тактикийг гаргах ажил ч бас багтана.”*

*“Үйл явц нь ихээхэн эмзэг, яагаад гэвэл энэхүү үйл явц нь хаалттай байсны дараагаар олон нийт, хэвлэл мэдээлэлд гарч эхэлсэн. Одоо ард иргэдэд нээлттэйгээр мэдээлэл түгээх хэрэгтэй.”*

Олон оролцогчид өнөөг хүртэл явуулсан үйл ажиллагаа нь Улаанбаатар хотод төвлөрсөн бөгөөд харин одоо олон талын оролцоот бүлгийн үйл ажиллагаа нь уул уурхайн үйл ажиллагаанд нэрвэгдээд байгаа иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон уурхай ажиллуулдаг компаниудад хүрэх ёстой хэмээн үзжээ.

Зарим оролцогчдын үзэж байгаагаар оролцоо болон мэдээлэл түгээх нь хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт болон зарчмуудад тулгуурлах хэрэгтэй бөгөөд үүний хажуугаар хууль болон иргэний эрхийн талаарх мэдлэг боловсрол олгоход тулгуурлах ёстой хэмээн үзэж байна. Бусад оролцогчид хариуцлагатай уул уурхайг орон нутагт хэрэгжүүлэх нь дараагийн чухал үйл ажиллагаа хэмээн үзсэн байна. Үүн дээр нэмээд оролцогчид олон талын оролцоот үйл явдалд уул уурхайн компаниуд оролцож байгаа ч хариуцлагатай уул уурхайн талаарх мэдээлэл нь яг газар дээрээ уурхай ажиллуулж буй хүмүүст хүрэхгүй байгаа мөн тэдгээр уурхай дээр ажиллаж, ажиллуулж байгаа хүмүүсийн дуу хоолой ч олон талын оролцоот үйл явцад ирж сонсогдохгүй байгаа талаар ярьцгааж байсан. Цөөн тооны оролцогч орон нутгийн төрийн байгууллага болон хяналтын ажилтнууд нь энэхүү хариуцлагатай уул уурхайн асуудалд мөн татагдан орох ёстой хэмээн үзсэн бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд олон талын оролцоот бүлэг нь орон нутгийн төрийн байгууллагуудад өөрсдийн эх үүсвэрийг хэрхэн зөв ангилан хариуцлагатай уул уурхайг дэмжих талаар туслах хэрэгтэйг сануулж байсан.

**Хувилбар:** Урт хугацааны олон нийтийн оролцооны стратеги боловсруулах



*Олон талын оролцоот үйл явц нь олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны талаар хэлэлцэж эхэлсэн бөгөөд үүний тоонд дараах үйл ажиллагаа орж байна:*

- *Ажлын хэсгээс санаачилсан олон нийтийг хамарсан кампанит ажил; болон*
- *Үйл явцад оролцсон иргэний нийгмийн байгууллагуудын хэрэгжүүлэх орон нутгийн хэмжээний үйл ажиллагаанууд.*

*Зарим оролцогч олон нийтийг татан оруулах тал дээр ихээхэн ач холбогдол өгсөнийг харгалзан үүнийг хангах талаар урт хугацааны төлөвлөгөө гаргах нь ашигтай байж болох юм хэмээн үзжээ. Энэ асуудлаар Азийн сангийн төлөөлөгчийн газар олон талыг татан оруулах стратеги төлөвлөх болон үүнийг хэрэгжүүлэх системтэй төлөвлөгөөг гаргахад туслалцаа үзүүлж болох юм.*

*Оролцооны дараагийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь орон нутгийн түвшнөөс олон талын оролцоот бүлгийн цаашидын үйл ажиллагаанд зориулан мэдээлэл түгээж байх явдал юм. Монгол Нутаг Мину эвслийн гишүүд жижиг хэмжээний олон талын оролцоот үйл явц болон орон нутагт мэдээлэл түгээх зэрэг орон нутгийн санаачлагуудыг талаар ярьцгааж байсан. Эдгээр орон нутгийн хэмжээний санаачлагийн үр дүнг цуглуулан олон талын оролцоот үйл явцад танилцуулж байх нь чухал байна. Орон нутгийн санаачлагаас авсан сургамжийг нэгдсэн үйл явцад мэдээлэн, хэрэгжилтийн бодит байдлыг баталгаажуулах нь зөв.*

### ✓ **Техникийн туслалцаа**

Найман оролцогч (36%) олон талт уулзалт нь бие даасан техникийн туслалцаагаар дамжуулан нэмэлт мэдээлэл цуглуулахыг дэмжсэн. Зарим ярилцагч хэлэхдээ бие даасан техникийн туслалцаа нь ерөнхийдөө оролцогчдын эрх мэдлийн тэнцэлийг хангахад ихээхэн тустай байсныг тэмдэглэсэн. Аль нэг талыг баримтлахгүй, бие даасан эксперт нь хамаарах бүх талуудын хэрэгцээнд нийцэхээр ажиллах зөвшөөрөл авч болно. Бусад ярилцагчид экспертийн туслалцаа шаардагдаж буй бусад салбаруудыг тогтоосон нь хууль зүйн, зохицуулалтын, нийгмийн, зах зээлийн болон байгаль орчны асуудлуудыг дүгнэн, шинжилгээ хийх явдлууд багтсан. Ярилцагчид мөн 5 дугаар хэсэг дээр тусгагдсан зүйлс дээр техникийн туслалцаа авахыг хүсэж байсан. Ийм төрлийн мэдээлэл нь ямар ч дэс дараалах, ач холбогдлоор нь ялгах, стратеги төлөвлөх, хэтийн төлөв тодорхойлох болон туршилтын төсөл хэрэгжүүлэх явцыг үр дүнтэй болохыг баталж болно.

**Сонголт:** Монгол улсын нөхөн сэргээлтийн стандартуудыг судлан дүгнэлт гаргах эксперт ажиллуулах

*Олон талт уулзалт нь Монгол улсын нөхөн сэргээлтийн зохицуулалтанд дүн шинжилгээ хийх, үүнийг олон улсын жишигт нийцүүлэн хэрхэн сайжруулж болох талаар зөвлөмж гаргах бие даасан зөвлөх ажиллуулах төсөл боловсруулах боломжтой юм. Экспертийн тайлан нь оролцогчдод мэдээлэл өгөх, олон нийт болон компаниудад боловсрол олгох аргачлал болох болон энэхүү хууль тогтоомжийг өөрчлөх талаар төрд нөлөөлөх зорилгод ашиглагдаж болно*

**Хувилбар:** Харьцуулсан эрсдлийн анализ

*Харьцуулсан эрсдлийн анализыг тухайн нэгэн асуудал нь хэрхэн нөлөөлж байгаа талаар шинжлэх ухааны баримттай мэдээллээр оролцогчдыг хангах улмаар тухайн асуудлуудыг шийдэх болон багасгах арга ажиллагааг санал болгох зорилгоор хийгдсэн. Харьцуулсан эрсдлийн анализ нь хүний эрүүл мэнд, экосистем болон бусад нийгэм эдийн засгийн хүрээнд үзүүлж байгаа аюул заналыг тодорхойлохыг хүсдэг. Дараагаар нь энэхүү үйл явц нь мэргэжлийн эрдэмтэд болон экспертүүдийг багтаасан техникийн ажлын хэсэг байгуулан тухайн аюулын цар болон аюулын хэмжээг тогтоодог ба үүнийг шинжлэх ухаанд суурилсан үнэлгээний системээр (жишээ нь техникийн цагаан ном гэх мэт) тухайн асуудал тус бүр дээр нь тооцдог. Дараагаар нь Техникийн групп нь өөрсдийн ажлаа үнэлгээний зорилгоор олон талын оролцоот форумд тайлагнана. Энэхүү дүн шинжилгээ нь шинжлэх ухаанаар батлагдсан мэдээллийг ашиглан иргэд бизнес эрхлэгчид болон төр засагт байгаль орчинд юу тохиолдоод байгааг ойлгоход тусалдаг бөгөөд үүгээр дамжуулан тухайн асуудлуудыг шийдвэрлэх бодлого боловсруулах болон ажлын төлөвлөгөө гаргах зэрэгт ашиглана. Энэхүү анализын хамгийн гол хэсэг нь олон нийтийн оролцоо юм.*

### ✓ **Уул уурхай болон хариуцлагатай уул уурхайн талаарх мэдээлэл**

Техникийн экспертүүдээс мэдээлэл авахын чухлыг дурдахаас гадна оролцогчид ерөнхийдөө өөр бусад зүйлсийг сурч мэдэх их хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Олон тооны оролцогч илүү гүнзгий мэдлэг олж авахыг хүсэж байгаа сэдвүүдээ санал болгосон. 7 оролцогч (32%) хэлэхдээ тэдэнд уул уурхайн салбар, уурхайн үйл ажиллагааны талаар мэдлэг хэрэгтэй байгаа бөгөөд тэд уул уурхайн бизнес,

*“Хариуцлагатай уул уурхай нь уурхай дээрээ ямар байх талаар нэгдсэн ойлголт дутагдалтай байна. ... Үүний хажуугаар уул уурхайн бизнес эрхлэх эдийн засгийн систем болон уул уурхайгаас үзүүлж багаа үр дүнгийн талаар ч ойлголт байхгүй байна.”*

уурхай дахь байгаль орчны удирдлага олон олборлох үйл явцын талаар гүн мэдлэгтэй болох нь ихээхэн ашиг тустай хэмээн үзсэн байна. Тухайн оролцогчдын зарим нь болон өөр бусад оролцогчид (нийт 7 хүн) хариуцлагатай уул уурхайн талаар, бизнесийн удирдлагын олон улсын шилдэг аргачлалын талаар, уурхайн үйл ажиллагааны талаар илүү ихийг мэдэхийг хүссэн байна. Олон тооны оролцогч уул уурхайн асуудлыг домог мэт байдлаас нь гаргах хэрэгтэйг дурдаж байсан. Зарим хүний хүссэнээр тусгай боловсролын үйл ажиллагаа явуулах шаардлагатай бөгөөд жишээ нь мөнгөн ус болон цианидын талаар, хэрхэн хэрэглэдэг, эрүүл мэнд болон байгаль орчинд нөлөөлөх байдал одоогоор хэрэглэж байгаа хамгаалах аргачлал зэргийн талаар дурдсан байсан.

**Сонголт: Цуврал лекц**

*Олон талын оролцоот үйл явц нь олон тооны мэргэжилтнүүдийг өөртөө багтаадаг бөгөөд үүний тоонд уул уурхайн салбар, судалгааны ажил зэрэг орох бөгөөд эдгээр хүмүүс нь шаардлагатай зарим мэдээллийг хангаж чадах юм. Олон талын оролцоот бүлэг нь үнэ төлбөргүй, олон нийтэд зориулсан лекц зохион байгуулж болох юм. Энэхүү цуврал лекц нь бүлгийн гишүүд ямар зүйл судлахаар хүсэж байгаа асуудлуудыг дэс дараалан, ач холбогдлоор нь тогтоож болно. Улмаар лекцийн сэдвүүдийн эргэн тойронд олон талын оролцоот бүлгийн гишүүдийн хооронд ярилцлага, хэлэлцүүлэг явуулж болох юм. Өөр нэг арга нь олон талын оролцоот уулзалтанд холбоотой техникийн мэргэжилтнүүд нь бүхэл бүлэгт зориулан мэдээллийн хуудас бэлтгэн, танилцуулга хийж болох юм.*

#### **4. Хариуцлагатай уул уурхайн төв болох санаа**

Ихэнх оролцогч судалгаа явуулах, мэдээлэл түгээх болон нөлөөллийн үйл ажиллагааг тэргүүлэх үүрэг бүхий төв эсвэл байгууллага болохыг онцлож бана. Энэ талаар гарсан саналуудын дотроос, зургаан ярилцагч (27%) хариуцлагатай уул уурхайн төв байгуулах талаарх тусгайлан дурдсан байна. Ихэнх оролцогч энэхүү төвийг байгууллага хэлбэрээр байгуулж бодлогын зөвлөмж гаргах, үүнийг нөлөөллийн үйл ажиллагаанд хэрэглэх, хариуцлагатай уул уурхайн стандартуудыг боловсруулах үйл ажиллагаанд хэрэглэхээр тооцож байна. Үүнээс гадна оролцогчид боловсрол, мэдлэгийн асуудлыг анхаарсан ба үүнийг төвийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж мэдээллийг идэвхтэйгээр дамжуулах, мэдээлэлд нэвтрэх боломж хангаж, уул уурхай, үүний эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлуудаар судалгаа хийхийг дэмжсэн байна.

Хэд хэдэн оролцогч төв байгуулах нь олон талын оролцогчдын уулзалтын албан ёсны байгууллага болох эсвэл бие даасан албан газар байгуулах гэсэн утга агуулаагүй хэмээн үзжээ. Тэдний саналаар энэхүү бүлэг нь тухайн төвийн явуулах үйл ажиллагааг тогтоох хэрхэн үйл ажиллагаа явуулах болон үүнийг үүсэн бий болсон цагаас нь эхлэн албан ёсний харилцаа тогтоож хамтран ажиллан, үйл ажиллагааг нь сайжруулах боломжыг дурдсан байна. Ярилцагчдын хоёр нь энэхүү төвийн засаглалын бүтцийг бий болгох нь гол сорилт бөгөөд үүнийг ойрын хугацаанд хийх хэрэгтэй гэж үзжээ. Гэхдээ тэд албан ёсоор байгуулахаас өмнө хэтийн төлөв, зорилгуудыг тогтоох нь зайлшгүй шаардлагатай хэмээн хэлжээ.

Гурван ярилцагч хэлэхдээ төвийн тулгарах гол сорилт нь байнга нээлттэй, нэг талыг бариагүй байх явдал бөгөөд үүнийг үйл явцын бүх оролцогч болох төр засаг, иргэний нийгэм болон бизнесийн хооронд зөв барих хэрэгтэйг онцолсон. Оролцогчид нь тухайн төвийг нээлттэй, шударга яриа хэлэлцээ явагддаг байдлаар төсөөлсөн бөгөөд үний үр



дүнд олон талын эрх ашгийг илэрхийлэх боломж олдоно гэж үзжээ. Энэхүү эрх мэдлийн тэнцлийг бүлгүүд оролцогчдын хооронд хангахын тулд оролцогчид төвийг сахисан, зөвлөхийн үүргийг энэхүү төвд ихээхэн тустай хэмээн үзжээ.

## 5. Найман зарчимд тохируулан стандартуудыг боловсруулах

Арван нэгэн ярилцагч (50%) стандарт эсвэл шалгуурууд боловсруулах талаар санал өгсөн ба үүгээр дамжуулан хариуцлагатай уул уурхайн найман зарчмуудыг хэрэгжүүлж болно хэмээн үзжээ. Стандартууд нь компаниуд хариуцлагатай хэмээн тооцогдохын тулд ямар зүйлсийг дагаж мөрдөхийг зааж өгөх ёстой. Өөр бусад олон улсын хэмжээнд явагдаж байгаа хариуцлагатай уул уурхайн санаачлагууд нь тодорхойлолт, зарчмын түвшнээс дээшлэн хэрэглэгдэх тусгай стандартуудыг гаргасан байна. Гэхдээ бусад хариуцлагатай уул уурхайн санаачлагууд өөр бусад аргуудыг гаргасан бөгөөд үүний тоонд гуравдагч талын гэрчилгээжүүлэлт (Уул уурхайн гэрчилгээжүүлэлтийн үнэлгээний төсөл, хавсралт 2 ийг үзнэ үү) зэрэг багтаж байна. Гаргасан санал нь олон төрөл стандартуудын түвшин тэднийг хэрхэн ашиглах талаар мөн дурджээ.

*“Стандартуудыг боловсруулснаар бид цаашид хэрхэн хариуцлагатай уул уурхайг бий болгох асуудлууд болон ойлголтыг бий болгоно.”*

Зарим оролцогч стандартуудыг зөвхөн төрийн зохицуулалтын нэгээхэн хэсэг хэмээн үзсэн. Оролцогчид олон талын оролцоот бүлгээс зохицуулалтын зааварчилгаа гаргах талаар ярьсан бөгөөд үүнийг нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглан төрийн байгууллагуудаар энэхүү стандартыг хүлээн зөвшөөрүүлж болох боломжийг дурдсан. Оролцогчид үүнийг экспертний тусламжаар бусад орон дахь зохицуулалтын системийг судалснаар хийж болно хэмээн үзсэн. Жишээ нь оролцогчид бусад орнууд дахь нөхөн сэргээлтийн стандартыг судлах хүсэлтэй байсан ба үүнийг Монголын нөхцөлтэй харьцуулах боломтжой болохыг дурдсан. Олон талын оролцоот бүлэг нь мөн газрын хэвлийн нөхөн сэргээлтийн талаар төрийн зохицуулалтыг сайжруулах талаар зөвлөмж гаргаж болохыг дурдсан. Зохицуулалтын бүтэц бий болгон үүнийг хэрэгжүүлэх хүчирхэг систем бий болгохыг дэмжих нь Монгол улсын хариуцлагатай уул уурхайн брендийг бий болгоход тохирох ба үүнийг хавсралт 7 ийн IV.В хэсэгт дурдсан.\

Зохицуулалтын асуудлын эсрэгээр бусад хариуцлагатай уул уурхайн санаачлагууд үйл явцад суурилсан элементүүдийг агуулсан сайн дурын стандартуудыг гаргасан байна. Эдгээр систем нь зах зээл дээрээс үзүүлж байгаа дарамт шахалтад хариу өгөх, үйлдвэрлэгчийн хийсэн "бүтээгдэхүүнийг" хариуцлагатайгаар хийсэн гэдгийг харуулах систем юм. Бусад бүлгүүд нь үүнийг ихээхэн ашигтай хэмээн үзсэн бөгөөд учир нь төрөөс тогтоосон стандарт нь зарим талаар учир дутмаг байж олон талын оролцоот бүлгийн чухал хэмээн үзсэн зүйлсийг агуулаагүй байх нь элбэг ажээ. Жишээ нь засгийн газрын бодлогоор олон нийтэд шийдвэр гаргалтад оролцох боломж олгох боловч түүнийг заавал олгох болон хязгаарлах байдал нь мөн нээлттэй байдаг. Хариуцлагатай уул уурхайг байлгахын тулд олон нийтийн ихээхэн өндөр түвшний оролцоотой байж үүнийг баталгаажуулж байх хэрэгтэй.

Олон нийтийн оролцооны хэмжээ болон чанарыг тогтоож болох хэмжих стандартыг тогтоох хэд хэдэн арга байгаагийн тоонд үйл явцад тулгуурласан стандартууд ба үүнийг бусад хариуцлагатай уул уурхайн санаачлагууд хэрэглэдэг. Энэхүү тайлан нь өөр бусад уул уурхайн санаачлагуудын хэрэглэдэг стандартууд болон үйл явцад

суурилсан стандартын гурван жишээг багтаасан. Тэдгээрийн бүгдийг нь сайн дурын үндсэн дээр боловсруулсан гэдгийг дурдах нь зүйтэй.

**Сонголт:** Одоогийн хэрэглэгдэж байгаа хариуцлагатай уул уурхайн стандартуудыг авч үзэх

*Энэ тайлангаар өөрийн гэсэн стандартуудыг боловсруулсан гурван өөр хариуцлагатай уул уурхайн санаачлагийн талаар дурдсан. Эдгээр санаачлага болгоны танилцуулга болон түүний стандартуудыг нь хавсралтад өгсөн байгаа. Доорх мөрүүдэд эдгээр кейс судалгааны загвар стандартууд болон хамаарах зарчмуудыг мөн багтаасан. Олон талт уулзалт нь одоогийн хэрэглэгдэж байгаа стандартуудыг Монголд хэрэглэх, тааруулан өөрчлөх аргуудыг хэрэглэх магадлалтай юм.*

**Хавсралт 2: Уул уурхайн гэрчилгээжүүлэлтийн үнэлгээний төслийн танилцуулга болон уул уурхай байгаль орчин болон нийгмийн хариуцлагын гуравдагч талын гэрчилгээжүүлэлтийн стандартууд**

**Загвар зарчим:** Байгаль орчны удирдлагийн үйл ажиллагааг байнга сайжруулахыг эрмэлзэх.

**Энэхүү зарчимд тохирох загвар гэрчилгээжүүлэлтийн стандарт:**

- Шинэ төслүүдийн байгаль орчинд үзүүлэх эерэг болон сөрөг, шууд ба шууд бус мөн хуримтлагдах нөлөөг үнэлэх - олборлолтын үеэс хаах хүртэл;
  - Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, хуримтлагдах нөлөөлөл зэргийг бүрэн хэмжээний хамаарал бүхий суурин мэдээлэл дээр үндэслэн судлах, мэдээллийг цуглуулахдаа шинэ төслийн олборлолт эхлэхээс эхлээд дуусах бүх цаг хугацаанд хянаж үнэлж байх.
  - Мониторинг, үнэлгээ тайлагнах зэрэг үйл ажиллагаа нь уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон нөлөөлөлтэй хамааралтай, тохирох байдлаар явагдаж байгаа.
- Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байнга шалгаж, нөлөөллөөс хамгаалж, бууруулж, багасгах зориулагдсан байгаль орчны удирдлагийн системийг хэрэгжүүлэх;
  - Уурхайн үйл ажиллагаанд байгаль орчны удирдлагийн системийг хэрэгжүүлж үүнийг олон улсад хүлэн зөвшөөрөгдсөн удирдлагын стандарт болон ISO 14001 болон үндэсний орон нутгийн бусад стандартуудад нийцүүлсэн байх.
  - Байгаль орчны удирдлагийн системийн үр дүнг байнга шалган байгаль орчныг сайжруулах тал дээр ахиц дэвшил гаргаж байх.

**Хавсралт 3: Олон улсын уул уурхай төмөрлөгийн зөвлөлийн төслийн танилцуулга болон хариуцлагатай уул уурхайг компанийн түвшинд гэрчилгээжүүлэх гуравдагч талын систем.**

**Загвар зарчим:** Байгаль орчны удирдлагийн үйл ажиллагааг байнга сайжруулахыг эрмэлзэх..

**Зарчмын загвар тайлангийн стандарт болон үзүүлэлтүүд:**

- Ашиглаж буй нийт материалын жагсаалт, үүнд ус багтана,
- Тайлагнаж байгаа байгууллагаас гадуурх эх үүсвэрээс хаягдал болон гарч байгаа хаягдал (боловсруулсан болон боловсруулаагүй) материалын хувь хэмжээ
- Үндсэн эх үүсвэрээр нь хуваасан шууд болон шууд бус энергийн хэрэглээ
- Хаягдаж байгаа хогын хэмжээ нь төрөл болон хаягдаж буй газраар
- Хаягдал усны хэмжээ төрлөөрөө
- Овоолго, хөрс, үлдэгдэл болон хаягдлын удирдлагын талаарх хандлага. Үүнд доорх зүйлс мөн багтана:
  - Эрсдлийн үнэлгээ;
  - Хадгалах төхөөрөмжийн бүтцийн чадавх;
  - Метал баяжуулах чадвар; болон
  - Хорт шинж чанар

**Хавсралт 5: Австралийн уул уурхайн омбудсманы Уул уурхайн аж үйлдвэрт хүний эрхийг хамгаалах талаарх үнэлгээг гүйцэтгэх стандартууд болон төслийн танилцуулга.**

**Загвар зарчим:** Уул уурхайн төслийн төлөвлөлт болон хэрэгжилт нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийх.

**Зарчимд хамаарах загвар стандарт:**

- Санал болгож байгаа хаягдлын аргад (овоолго болон ил хайх) шууд нэрвэгдэх хүмүүс тухайн компанитай энэхүү аргын талаар ярилцаж хаягдлыг байршуулах зөв арга олох хэрэгтэй бөгөөд тэдэнд бүх талуудын сонирхолд нийцсэн арга дээр зөвшилцөхөөс нааш хаягдалгүй орчинд (бодит хэрэг дээрээ уул уурхайн олборлолтгүй орчинд амьдрах) амьдрах эрхээ эдлэнэ
- Компаниуд нь уурхайн эргэн тойронд байгаль орчны мониторинг хийх системийг ажиллуулж энэхүү орчны хүрээнд голын ай савыг багтаан хэрэв энэхүү алдаа илэрсэн бол нэн даруй засаж залруулах арга хэмжээг авна. Энэхүү систем нь засгийн газраас баталсан бие даасан, баталгаажуулалтын системд хамрагдах бөгөөд үүнийг компани бус харин олон нийт болон иргэний нийгмийн байгууллагууд сонгон авах болно. Үүнээс гарсан бүх дүгнэлтийг олон нийтэд танилцуулж ил тод байдалд байлгана.
- Төсөл эхлэхээс өмнө уурхайг хаах төлөвлөгөөг бүрэн гаргасан байна. Энэхүү төлөвлөгөөг бүх олон нийтийн оролцоотойгоор гаргана. Хамгийн багаар үзэхэд компанийн үндсэн бүртгэлтэй болон үйл ажиллагаа явуулж буй орны хамгийн дээд стандартыг даган мөрдөх ёстой. Төлөвлөгөө нь жилд хоёр удаа шалгагдан өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалд нийцтэй эсэхийг баталгаажуулна

Оролцогчид мөн стандарт боловсруулах тал дээр санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Хэд хэдэн хүн энэ талаар сануулан хэлэхдээ юуны өмнө үүнийг хэрэгжүүлэх эрүүл системийг одоогийн зохицуулалтын хүрээнд бий болгох нь чухал бөгөөд учир нь одоогийн систем нь ихээхэн сорилтуудтай тулгараад байгаа ажээ. Хэрэв бүлэг нь сайн дурын стандартын системг сонгон авбал одоогийн зохицуулалтын систем дэх хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай ба үүнийг сайн дурын стандарттай зэрэгцүүлэн хэрэглэж эсвэл одоогийн хэрэглэж буй зохицуулалтын системээс давж гарахаар хэмжээнд хэрэглэх хэрэгтэйг дурдаж байсан. Энэ тохиолдолд сайн дурын болон зохицуулалтын стандартууд нь бие биетэйгээр харилцан тохирч байгаар сайтар шалгахыг зөвлөж байна.

Зарим оролцогчид анхааруулан хэлэхдээ стандартуудыг (ямар төрлийн?) боловсруулах нь хэт эрт байна гэж үзсэнээ дурдаад эсвэл энэ нь Монголд тохиромжгүй гэж үзэж байгаагаа мөн илэрхийлсэн. Өөр нэг оролцогч хэлэхдээ судалгааны шатнаас эхлэн үе шаттайгаар стандартуудыг хоёр жилийн хугацаанд боловсруулж, улмаар олон нийтээр хэлэлцүүлэх зэргээр санал хүсэлтийг нь судлан эцсийн дүнд төр засгийн зүгээс хүлээн зөвшөөрөх байдлаар төсөөлж байсан. Өөр нэг оролцогчийн хэлснээр найман зарчмын нэг дээр нь туршилт байдлаар стандарт боловсруулж туршиж үүнд ямар сорилтууд тулгараад байгааг тогтоож болох санал мөн хэлж байсан.

## V. АСУУДЛЫН ГОЛ ЦЭГ

Цаашдын чиглэлийн хүрээнд, оролцогчид нь өөрсдийн өөр бусад хэд хэдэн зүйл дээр төвлөрүүлсэн. Оролцогчид нь эдгээр асуудлууд нь ихээхэн ач холбогдолтой гэж үзсэн ба эдгээрийг шийдсэнээр Монгол дахь хариуцлагатай уул уурхайд дэвшил гаргана хэмээн үзжээ. Эдгээр асуудлууд нь олон талт уулзалтын бүлэг шийдвэрлэж чадах хэмжээний асуудлууд юм. Доорх асуудлууд нь нийт 22 ярилцлагад дурдагдсан бүх



асуудалд багтаагаагүй бөгөөд харин хамгийн олон давтагдсан хэсгүүдийг багтаасан болно.

### 1. Эрх зүйн асуудлууд

Арван гурван хүн (59%) авилга, хууль эзэнгүйдэх байдал болон лиценз олголт нь Монгол дахь эрх зүйн хүрээний хамгийн чухал асуудлууд болоод байгааг дурдсан. Зарим оролцогчийн итгэж байгааг одоогийн хууль дүрмүүд хатуу чанга боловч бусад хэсэг нь энэхүү хууль

*“Ашигт малтмалын салбарын хууль тогтоомжууд нь байгаль орчин, ил тод байдал, олон нийт иргэдийн оролцоо, орчин үеийн технологи ашиглалт, уул уурхайн компани болон төрийн харилцааны тал дээр чанга хатуу заалттай боловч үүний хэрэгжилт нь маш сул байна.”*

тогтоомжуудыг улам чангатгах хэрэгтэй гэж үзжээ. Гэхдээ ярилцлагад орсон хүн бүгд одоогийн хууль тогтоомж нь авилгын улмаас жигд мөрдөгдөхгүй байгаа нь уул уурхайн компаниуд хуулийг хүндлэхгүй байх нь гол аюулыг учруулж байгаа ажээ. Үүн дээр нэмээд байгал орчны олон зохицуулалтын хяналтын асуудал нь ихээхэн саад бэрхшээлтэй тулгараад байгааг хүмүүс дурдаж байсан. Улсын мэргэжлийн хяналтын газар нь санхүүжилт, мэргэжлийн ажилчид, хяналтын хүрээ, шалгалт явуулах хүчин чадал дутмаг байдаг байна. Ашигт малтмалын лиценз олгох систем нь хуулийн хэрэгжилтийг хүндрүүлж байна гэж үзжээ. Олон тооны оролцогчид буруу аргаар олборлолт хийх, болон олборлох лицензийг буруу аргаар өгөх асуудал дээр санаа зовниж байсан бөгөөд энэхүү лиценз олгох ажилд олон нийтийн хамруулах, татан оруулах талаарх арга замыг хайхыг санал болгож байсан.

### 2. Гар аргаар ашигт малтмал ашиглах асуудлууд

Долоон оролцогч (32%) гар аргаар ашигт малтмал олборлогчид буюу нинжа нар нь хариуцлагатай уул уурхайд тулгараад байгаа гол нэг асуудал хэмээн үзсэн байна. Ихэнх оролцогчдын хэлснээр гар аргаар ашигт малтмал олборлох хуулийг одоо Их хурлаар хэлэлцэж байгаа нь Монгол орны хувьд хийж байгаа нэгэн чухал алхам болохыг тэмдэглэсэн. Гар аргаар ашигт малтмал олборлох хуулийг батлах нь гар аргаар ашигт малтмал олборлогчдыг хэрхэн олон талт уулзалтын үйл явцад, үүний хариуцлагатай уул уурхайн үзэл баримтлалд хамруулах талаарх бодлогыг тодорхойлох ажээ. Хэд хэдэн тооны ярилцагч хэлэхдээ гар аргаар ашигт малтмал олборлох нь хариуцлагатай уул уурхай биш, албан ёсны уурхайнуудад гар аргаар ашигт малтмал олборлогчдод зориулан ажлын байр бий болгох зэрэг бусад аргыг хайх хэрэгтэйг дурдсан байна.

### 3. Ил тод байдал

Долоон оролцогч (32%) хэлэхдээ ил тод байдал, ялангуяа санхүүгийн ил тод байдал нь хариуцлагатай уул уурхайн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзсэн байна. Ил тод, нээлттэй байдлыг оролцогчид уул уурхайн компани, төр засаг, иргэний нийгмийн дунд харилцан итгэлцэл бий болгоход туслах зүйл хэмээн үзжээ. Олон талт уулзалтын бүлгийн гишүүн зарим оролцогч Монгол улсын Олборлох салбарыг ил тод байдлын санаачлагийн гишүүн байлаа. Энэ санаачлагыг Монгол улсын ерөнхийлөгч санаачилсан бөгөөд энэ нь уул уурхайн компаниуд болон бусад олборлох салбарын санхүүгийн тайлангийн ил тод байдалд зарим нэгэн шалгуур тавьж өгдөг юм. Оролцогчдын найдаж байгаагаар олон талт уулзалтын үйл явц болон Олборлох

салбарын ил тод байдлын санаачлага нь өөрсдийн үйл ажиллагааг цаашид хамтдаа уялдуулан зохион байгуулна хэмээн үзэж байна. Санхүүгийн ил тод байдал дээр нэмээд оролцогчид уул уурхайн компанийн ил тод байдлын талаар ерөнхийлөн ярьцгаасан бөгөөд үүнд мөн байгаль орчны удирдлагын систем багтаж байсан. Оролцогчид Хятад, Орос болон Монголын уул уурхайн компаниудын ил тод, нээлттэй байдлын талаар санаа зовж явдгаа илэрхийлсэн.

#### **4. Нөхөн сэргээлт**

Таван хүн (23%) нөхөн сэргээлтийн талаарх сонирхлоо илэрхийлсэн. Монгол улсад нөхөн сэргээх талаарх зарим асуудлууд нь хүний нөөц болон техникийн боломж, зохицуулалтын заавар дутмаг байх, хяналт шалгалтын хүчин чадал сул байгаагаас болдог хэмээн үзжээ. Үүнээс гадна засгийн газрын зүгээс нөхөн сэргээлт хийх ёстой хаягдсан уурхайнууд байгаа бгөөд энэ тал дээр санхүүжилт дутагдалтай байдаг ажээ. Зарим хүн нөхөн сэргээлтийн тухай олон улсын сайн аргачлалын талаар мэдээлэл авахыг хүсэж байсан. Энэхүү тайлангийн Хавсралт 8 дээр АНУ-ын нөхөн сэргээлтийн талаарх материалуудыг тавьсан болно.

#### **5. Бусад асуудлууд**

Нэгээс илүү тооны оролцогчдоос өөр хэд хэдэн асуудлуудыг гарган тавьсан боловч эдгээр нь дийлэнх олонхын санал бодол байгаагүй юм. 4 ярилцагч (18%) цөлжилт, усны нөөцийн болон чанарын хомсдлыг гарган хэлсэн, гэхдээ эдгээрийг ерөнхий байгаль орчны чиглэлд хамруулан ойлгож болох юм. Үүний зарим хэсэг нь уул уурхайн үйл ажиллагаатай холбоогүй бөгөөд зарим нь бүхлээрээ холбоогүй тул ийм шийдэлд хүрсэн болно.

## **VI. ДҮГНЭЛТ**

### **1. Үйл ажиллагаа явуулах хувилбаруудын талаарх тойм**

Оролцогчдын өөрсдийнх нь гаргасан саналыг харгалзан үзвэл цаашдын үйл ажиллагаа хэрхэн явуулах талаар олон хувилбар байгаа ба эдгээр нь бүгд олон талын оролцоот бүлгийн давуу талууд дээр суурилж, сул талуудыг засан залруулсан чиглэлтэй байгаа. Нийтдээ аваад үзвэл оролцогчид тухайн үйл явц, Азийн сангийн үүрэг роль, дэмжлэг болон байгууллагын бүтцэд үзүүлсэн туслалцаанд сэтгэл хангалуун байна. Оролцогчид нь хамтран ажиллах боломж, яриа хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг өндрөөр үнэлэн тухайн бүлэг нь цаашдаа илүү их албан бус сүлжээний үйл ажиллагааг төлөвлөн, онцгой нэгэн асуудлаар харилцан яриа өрнүүлэх бүтцийг бий болгох саналыг гаргаж байна. Хэдийгээр оролцогчид байнгын ажиллагаатай ажлын хэсэгтэй байхыг дэмжиж буй ч энэхүү бүлгүүдээс нэгдсэн бүлэгт үйл ажиллагаагаа нарийвчлан тайлагнаж байхыг хүссэн байна. Үүн дээр нэмээд мөн бүлэг нь уул уурхайн компаниудын оролцоог нэмэгдүүлэх талаар ажиллах, илүү олон хүмүүс болон олон компани төлөөллийг нэмэгдүүлэхийг санал болгожээ.

Оролцогчид нь хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт, зарчмууд болон тунхаг нь нэгдмэл ойлголцлыг бий болгосноороо цаашдын үйл ажиллагааны чухал үндэс суурь болсон хэмээн дүгнэжээ. Гэхдээ тэд хурдан хугацаанд ойрын шатны ялалт байгуулахыг уриалж Монгол улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийг хүссэн байна.

Олон талын оролцогчдын уулзалтын цаашдын чиглэлийн талаар асуухад бүлэг нь өөрийн стратегийн зорилтыг тодорхойлон өөрсдийн байр суурь давуу талуудыг ашиглан **хэрхэн** хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилго чиглэлээ тогтоохыг санал болгосон байна. Оролцогчид үйл явцын нийт стратеги болон ажлын төлөвлөгөөг гаргахыг хүсэж ингэснээр хариуцлагатай уул уурхайн асуудлыг өргөн хүрээнд харж дэмжиж чадна хэмээн үзсэн байна. Стратегийг үзэл баримтлалдаа хамруулах нь богино хугацаанд амжилт авчран зорьсон нийт зорилгоо хүрэх чиглэлийг заана хэмээн үзжээ. Стратеги боловсруулах болон ач холбогдлоор нь жагсаах олон хувилбар байгаа бөгөөд үүгээр дамжуулан цаашдын зорилго болон төлөвлөлтийг гүйцэтгэж болно. Үүн дээр нэмээд хариуцлагатай уул уурхайн болон хариуцлагатай бизнесийг хэрэгжүүлсэн өөр бусад бүлгүүдийн үйл ажиллагааны жишээ, сайн аргачлалууд байгаа нь энэхүү бидний үйл ажиллагаанд нэмэлт мэдээлэл болж өгөх юм.

Олон хүн санал болгохдоо ойрын хугацааны боловсрол мэдлэг олгох үйл ажиллагааг явуулахын чухлыг дурдсан байна. Олон нийтийн оролцоо, мэдээлэл түгээх, орон нутгийн түвшний хэрэгжилтийг иргэд, төр, бизнес, иргэний нийгэм уул уурхайн салбарын төлөөллийг хариуцлагатай уул уурхайд татан оруулах чухал шат хэмээн үзэж байна. Энэхүү асуудалд аргачлалтайгаар хандахад удаан хугацааны олон нийтийн оролцооны төлөвлөгөөг эргэх холбооны механизмтайгаар боловсруулах шаардлагатай байна. Энэхүү үйл явцад мэдээлэл олгох зорилгоор оролцогчид нь Азийн сан болон бусад эх үүсвэрээс санхүүжилт хайн бие даасан техникийн туслалцааг бүлгээс тогтоон гаргасан тусгай асуудлууд дээр авах шаардлагатай байна. Улмаар оролцогчид нь уул уурхайн болон хариуцлагатай уул уурхайн талаар илүү их зүйлийг сурч мэдэхийг хүсэж байгаа тул үүний орон нутгийн цуврал лекц зэрэг байдлаар зохион байгуулж бизнес болон уул уурхайг домог биш бодит байдалд ойртуулах хэрэгтэй байна.

Оролцогчдын үзэж байгаагаар ойрын хугацааны ажил нь хариуцлагатай уул уурхайн төв байгуулах ажилд хувь нэмэр оруулах нь чухал байна. Гэхдээ төвийн үйл ажиллагааны төлөвлөлт, зорилго, стратегийг тодорхойлоход юуны өмнө олон талын оролцоот бүлгийн зорилго, стратегийг тогтоох нь чухал байна.

Оролцогчдын хагас нь хариуцлагатай уул уурхайн найман зарчимд хамаарах тусгай стандарт эсвэл шалгууруудыг гаргахыг дэмжжээ. Гэхдээ стандартын төрөл дээр нэгдсэн зөвшилцөлд хүрээгүй бөгөөд үүнийг хэрхэн боловсруулах хэрэглэх дээр санал нэгдээгүй байгаа. Стандарт боловсруулах хэд хэдэн жишээ байгаа хэрэв бүлгээс энэхүү үйл ажиллагааг явуулахааар шийдвэл хэрэглэх боломжтой юм.

## **2. Харгалзан үзэх асуудлууд**

Энэхүү үнэлгээний хүрээнд олон талт уулзалт нь өөрийн үндэс сууриа сайн тавьсан бөгөөд харин одоо бүлгийн цаашдын үйл ажиллагааны талаар бодож эхлэх чухал цаг мөч ирээд байна. Олон талын оролцогчдын уулзалтын бүлэг нь “Бид Монголын хариуцлагатай уул уурхайг **хэрхэн** хөгжүүлэх в?” гэсэн асуултад хариулах цаг болжээ. Энэхүү үйл явцын зорилго болон стратегийг тодруулсанаар оролцогчид нь хэрхэн хувь хүний үйл ажиллагаа томоохон хүрээнд тохирч, хэрхэн хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх вэ гэдгийг илүү гүнзгий ойлгох болно.

Энэхүү тайлан нь бусад бүлгүүд өөрсдийн хариуцлагатай уул уурхайн асуудлаар хөгжихдөө хийсэн жишээнүүдийг болон тэдний зорилгыг, хэтийн төлөвийг

тодруулахдаа хийсэн алхамуудыг жишээ болгон дурдсан. Гэхдээ олон талын оролцогчдын уулзалтын бүлэг нь цаашдаа өөрсдийн чухал гэж үзсэн асуудлууд дээр илүү дэлгэрэнгүй судалгаа хийж, хэрхэн бусдын сургамж Монголд хэрэгжиж болохыг судлах шаардлагатай.

Энэхүү үнэлгээг явуулсан хүний хувьд миний бие энэхүү бүлгийн гаргасан ахиц дэвшил, оролцооны чанарт маш их сэтгэл хангалуун байна. Олон талын уулзалтын оролцогчид нь зургаахан сарын дотор хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт болон зарчмуудыг гаргасан нь бусад олон талын оролцогчдын уулзалтын бүлгүүдийн гурав дахин удаан хугацаанд ажиллан дөнгөж тодорхойлолт дээрээ зөвшилцсөнтөй харьцуулшгүй юм. Оролцогчдын энерги болон оролцооны чанар нь маш сэтгэл хөдлөм байлаа.

Энэхүү энергийг оролцогчид нь цааш нь улам хөгжүүлж, үргэлжлүүлэх нь ихээхэн чухал учир нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх ахиц дэвшил нь оролцогчдын хичээл зүтгэл, нөөц эх үүсвэрээс ихээхэн хамааралтай. Нэг оролцогчийн хэлснээр, “Олон талт уулзалтын үйл явц нь олон талын ур чадвартай бөгөөд энэхүү ур чадвараа ашиглавал цаашид ихээхэн амжилтад хүрч чадна” гэсэн үгээр төгсгөө.